# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 46 (379)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай*
- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ:

- *Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2004 оны арванхоёрдугаар сарын 14 №46 (379)


## Гарчиг


**Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:**

| | | | |
|---|---|---|---|
| 439. | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай | Дугаар 26 | 831 |
| 440. | Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай | Дугаар 27 | 861 |

**Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:**

| | | | |
|---|---|---|---|
| 441. | Гарамжавын Сундуйжавт улсын тод манлай уяач цол олгох тухай | Дугаар 182 | 862 |
| 442. | Зарим уяачид улсын манлай уяач цол олгох тухай | Дугаар 183 | 862 |
| 443. | Зарим уяачид улсын алдарт уяач цол олгох тухай | Дугаар 184 | 862 |
| 444. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 186 | 863 |
| 445. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 187 | 863 |

**Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ:**

| | | | |
|---|---|---|---|
| 446. | Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр батлах тухай | Дугаар 95 | 863 |


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 12 дугаар сарын 02-ны өдөр** | **Дугаар 26** | **Улаанбаатар хот**

### Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2005 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Бодлогын зорилт | Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх албан тушаалтан |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| | **НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГА, ИРГЭНИЙ ОРОЛЦОО** | | |
| 1.Хүний эрх, эрх чөлөө, иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн баримт бичгүүд, стандартын шаардлагуудыг шинэчлэх зорилтын хүрээнд | -Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах явцыг нээлттэй болгож, дээрх асуудлыг аль болох ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тал болон иргэдийн санаа бодолд тулгуурлаж шийддэг жишиг тогтооно. | жилдээ | Засгийн газрын гишүүд |
| | -Төрийн албан хаагч иргэдэд үйлчлэх, эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ мөрдөх албаны болон ёс зүйн журмыг гаргаж, түүнийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэн олон нийтийн хяналтын дор хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ. | жилдээ | Ж.Норовсамбуу Ц.Нямдорж |
| | -Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчийн ёс зүй, иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанарыг сайжруулах, хариуцлага хүлээлгэх зарчмыг тодотгох чиглэлээр өөрчлөлт оруулна. | жилдээ | Ж.Норовсамбуу С.Баярцогт Ц.Нямдорж |
| | -Төрийн алба, үйлчилгээнд түвшин тогтоож, түүнийг гүйцэтгэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад илүү нээлттэй болгоно. | жилдээ | Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар |
| | -Төрийн төв болон орон нутгийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээг тодотгож, эрх, үүргийн шилжилтийг үр дүнд тулгуурлан нарийвчлан тогтоох ажлыг эхлүүлнэ. | жилдээ | С.Баярцогт аймаг, нийслэлийн Засаг дарга нар |
| | -Төрийн байгууллагын эрхэмлэх зорилго, шийдвэрлэх асуудал, түүнд тавигдах шаардлага зэргийг нийтэд ил тод байлгана. | жилдээ | Засгийн газрын гишүүд |
| | -Нийгмийн бүх салбарт хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлын стандартыг хангах, түүнийг баталгаажуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. | жилдээ | Засгийн газрын гишүүд |
| | -Иргэдийн нууц, хувийн өмч хөрөнгө, орон байрны халдашгүй дархан байдлыг хуулиар баталгаажуулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хуулиар зөвшөөрсөн аливаа мэдээлэлтэй танилцах, мэдээлэл гаргуулан авах хүсэлт тавих, түүнийгээ хэрэгжүүлэх эрхээр иргэдийг хангана. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Үндэсний радио, телевизийг төрийн мэдлээс гарган, тэдгээрийн зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж эрх зүйн орчныг бий болгоно. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, ерөнхий менежерийн чадавхийг хөгжүүлэх зорилтыг салбаруудын стандартын шинэ шаардлагыг гаргаж мөрдүүлэхтэй шууд холбоотойгоор хэрэгжүүлнэ. | жилдээ | Ж.Норовсамбуу С.Баярцогт Засгийн Газрын гишүүд |
| | -Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Засгийн газрын гишүүд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Төр, нийгмийн бүх салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг арилгана. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих соёлыг хэвшүүлж эхэлнэ. | I байнга | Ц.Баярсайхан Н.Алтанхуяг |
| | -Ядуурлыг бууруулах мониторингийн тогтолцоонд жендерийн статистик үзүүлэлтүүдийг тусгах, хэрэгцээт мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана. | жилдээ | Н.Алтанхуяг Ц.Баярсайхан |
| | -"Цахим засаглал" хөтөлбөр хэрэгжүүлнэ. | жилдээ | С.Баярцогт |
| | -Татвар, гааль, тендер, зайлшгүй байх бүртгэл, зөвшөөрөл болон иргэдийн шилжилт хөдөлгөөнтэй холбогдсон үйлчилгээг сүлжээгээр дамжуулж хийх бэлтгэлийг хангуулна. | жилдээ | Н.Алтанхуяг С.Батболд Ц.Нямдорж |
| | -Төрийн албаны үйлчилгээг хялбаршуулж, цахим программд шилжүүлснээр төрийн албанд цаас хэрэглэх явдлыг багасгана. | жилдээ | Засгийн газрын гишүүд С.Баярцогт |
| | -Төрийн захиргааны байгууллагын аппаратыг чадварлаг болгох замаар албан хаагчдын цалинг өсгөж, үүрэг, хариуцлагыг нь нэмэгдүүлнэ. | жилдээ | Засгийн газрын гишүүд |
| | -Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг боловсронгуй болгон, хяналт шалгалтыг хуулийн хүрээнд явуулж хэвшүүлнэ. | жилдээ | И.Эрдэнэбаатар |
| | -Хууль тогтоомж стандартын биелэлтэд тавих мэргэжлийн хяналт, шалгалтыг чанаржуулан төрөөс иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэг төрөл болгоно. | жилдээ | И.Эрдэнэбаатар |
| | -Хяналт шалгалтын ажлыг баталгаажуулах зорилгод нийцүүлэн мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторийн чадавхийг сайжруулах эхлэлийг тавина. | жилдээ | И.Эрдэнэбаатар |
| | -Монгол Улсын хууль тогтоомжийг 2004-2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг боловсруулан батлуулна. | I улиралд | Ц.Нямдорж |
| | -Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлд тавих хяналтыг боловсронгуй болгоно. | жилдээ | С.Баярцогт |
| | -Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно | жилдээ | Ц.Нямдорж |
| 2.Төрийн удирдлага, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, нийгмийн баялгийг бүтээхэд оролцох иргэдийн эрх, боломжийг өргөжүүлэх, зүй ёсны төвлөрлийг бодлогоор зохицуулах, түүхэн уламжлал, орчин цагийн шаардлагад нийцүүлэн засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг хийх хүрээнд | -Засаг захиргааны шинэтгэлийг хэрэгжүүлэх шаардлага, ач холбогдлын талаар өргөн хэлэлцүүлэг өрнүүлж, ард нийтийн санал асуулгаар уг асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдүүлнэ. Иргэдэд үзүүлдэг эрүүл мэнд, боловсрол, харилцаа холбоо зэрэг зайлшгүй шаардлагатай, төрийн үйлчилгээг хадгалах замаар одоогийн засаг захиргааны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах асуудлыг судална. | жилдээ | С.Баярцогт Ч.Улаан Н.Батбаяр |
| | -Бүсүүдийн байршлын онцлог, давуу тал, хөгжлийн боломжид нь нийцсэн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ. | жилдээ | Ч.Улаан Н.Батбаяр |
| | -Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | жилдээ | С.Баярцогт Ц.Нямдорж |
| | -Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгаж, үйлчилгээний хугацаа, хураамжийн хэмжээг оновчтой тогтоож мөрдүүлэх, зөвшөөрөл, лиценз олгох журмыг хялбарчлах, төрөөс иргэдэд бизнес эрхлэхэд нь ижил тэгш нөхцөл олгох чиглэлээр ажиллана. | жилдээ | С.Баярцогт Н.Алтанхуяг |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Хүн ам олноор төвлөрч үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх боломжтой хот суурин, бүсийн төвүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих ажлыг эхлүүлнэ. | жилдээ | С.Баярцогт<br>Н.Алтанхуяг |
| | -Хөдөө орон нутгаас хот, суурин газар руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг зах зээлийн аргаар зохицуулах механизм бүрдүүлэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Төрийн сүлд, далбаа, бэлгэдлийг иргэд өргөнөөр хүндэтгэн хэрэглэх, тэдэнд түүх, соёл, эх орноороо бахархах хүмүүжил олгохыг дэмжинэ. | жилдээ | П.Цагаан |
| | **ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД** | | |
| 1.Айл өрхийн хуримтлал бий болгох чадварыг нэмэгдүүлэн худалдан авах чадварыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллийг багасгах зорилтын хүрээнд | -МАХН, "Эх-орон ардчилал" эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон нийгмийн шинжтэй амлалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зорилттой уялдуулан оновчтой, хаягласан, хүндээ хүрсэн хэлбэрээр хангахыг зорьж "Хүүхдийн мөнгө" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур, 3 ба түүнээс дээш 0-18 насны хүүхэд бүхий өрхийн хүүхэд бүрт сар тутам 3000 төгрөг олгоно. Уг мөнгийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс олгож эхэлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | -Ядуурал, ажилгүйдлийн талаар хийгдсэн судалгаанд үндэслэн, түүнтэй тэмцэх бодлогыг хаягласан, үр дүнд тулгуурласан хэлбэрээр хэрэгжүүлж эхэлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг<br>П.Бямбацэрэн |
| | -Ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэх нь зөвхөн Засгийн газрын үүрэг гэсэн ойлголтыг өөрчилж, энэ үйл ажиллагаанд орон нутгийн удирдлагыг татан оролцуулна. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Ц.Нямдорж<br>С.Баярцогт<br>Н.Алтанхуяг<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга нар |
| | -Нийгмийн баялгийн хуваарилалтыг оновчтой, боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээг авилгал, хүнд суртлтай тэмцэх бодлоготой уялдуулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Н.Алтанхуяг<br>Ц.Баярсайхан<br>Ц.Нямдорж |
| | -Хүн амын орлогын албан татварын шатлалыг цөөрүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. | жилдээ | Н.Алтанхуяг<br>Ц.Нямдорж |
| | -Гэр бүлд зориулсан үл хөдлөх хөрөнгө, ялангуяа орон сууцны зээлийн тогтолцоог бүрдүүлнэ. | III улиралд | Н.Алтанхуяг<br>Н.Батбаяр<br>О.Чулуунбат |
| | -Хувийн орон сууцтай болох, орон сууцаа өргөтгөн сайжруулах явдлыг дэмжихийн хамт орон сууцны дэд бүтцийг тэргүүн ээлжинд байгуулах арга хэмжээ авна. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсооход чиглэсэн сургалт, сурталчилгаар өргөтгөж, хамгаалах үйлчилгээ, үйл ажиллагаар хүртээмжтэй, үр өгөөжтэй болгохын тулд иргэний нийгмийн санаачилга, оролцоог дэмжсэн үйл ажиллагаа явуулна. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -"40000 орон сууц" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжилтийг эхлүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр<br>Н.Алтанхуяг |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 2.Боловсролын түвшинийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд хүргэх, иргэдийн сурч боловсрох эрхээ чөлөөтэй эдлэх боломжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд | -Боловсрол, шинжлэх ухаан, технологийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ. | жилдээ | П.Цагаан<br>Ц.Намдорж |
| | -Монгол Улсын боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулна. | жилдээ | П.Цагаан |
| | -Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, байршил болон дотуур байрны байршил, хангамжийг оновчтой болгоно. | жилдээ | П.Цагаан<br>Ч.Улаан |
| | -Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг зохион байгуулж, сургуулийн ачааллыг багасгана. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Багшийн мэргэжлийн чадавхи, үнэлэмжийг дээшлүүлнэ. Боловсролын салбарт хийх улсын төсвийн санхүүжилтийг багш нарт түлхүү зарцуулж, удирдлагын зардлыг бууруулна. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Ерөнхий боловсролын шинэ стандартыг мөрдөж эхлэхийн зэрэгцээ ерөнхий боловсролыг 11 жилийн тогтолцоонд шилжүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 45.0 хувь, суурь боловсролын хамран сургалтыг 90.8 хувьд тус тус хүргэнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Англи хэлийг хоёр дахь албан хэл болгох бэлтгэлийг хангахын тулд багш бэлтгэхэд хөрөнгө оруулалт хийж, сайн дурын багш нарын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Суурь болон бүрэн дунд боловсролын англи хэлний сургалтыг өргөжүүлж, чанаржуулна. | жилдээ | П.Цагаан |
| | -Англи хэлний болон мэдээллийн технологийн чиглэлээр сургалтын нэвтрүүлгүүдийг дэмжинэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Стандартын шаардлага хангасан сурах бичгээс сонголт хийх эрхийг эцэг, эх, сургуулийн захиргаа хамтран эдлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Сургууль завсардсан хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол нөхөн олгох зорилготой иргэний нийгмийн санаачлагыг дэмжинэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Эмзэг бүлгийн, бага орлоготой өрхийн болон 3 ба түүнээс дээш хүүхэд нь зэрэг сурдаг өрхийн 1 хүүхдэд хичээлийн хэрэгсэл үнэ төлбөргүй олгож байгааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Дээд боловсролын байгууллагын болон сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг үргэлжлүүлнэ. Магадлан итгэмжлэгдэх сургалтын байгууллагад тавигдах шаардлага, стандартыг олон улсын жишигт ойртуулна. | жилдээ | П.Цагаан |
| | -Боловсролын салбарт менежментийн хувьчлалыг үргэлжлүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээ мөрдөх бэлтгэлийг хангаж, сургалт, судалгааны ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Мэдээллийн технологийг дээд, дунд шатны боловсролын сургалтад нэвтрүүлэх ажлыг өргөжүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Монгол Улсын дээд боловсролын өрсөлдөх чадвар, үнэлэмжийг дээшлүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Сурагч, оюутны хувийн эрх чөлөөг хүндэтгэж нууцад нь хамаарах мэдээллийг хамгаалах аргыг туршин нэвтрүүлж эхэлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Мэргэжлийн боловсролын агуулга, стандартыг шинэчлэн сургалтын орчныг бэхжүүлж, нийгмийн түншлэлийг идэвхжүүлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлж, мэргэжлийн боловсролыг түлхүү хөгжүүлэх ажлыг эхэлнэ. | жилдээ | П.Цагаан<br>Ц.Баярсайхан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Мэргэжлийн сургалтад алсын зайн сургалтыг ашиглах боломж бүрдүүлнэ. | жилдээ | П.Цагаан<br>Ц.Баярсайхан |
| | -Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг сургалтын тоног төхөөрөмжөөр хангаж, эдгээр сургууль, төвийн 25 хувийг тогтоосон стандартын дагуу компьютержүүлж, сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | П.Цагаан<br>Ц.Баярсайхан |
| | -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг сурах бололцоогоор хангаж, зориулалтын тоног төхөөрөмж, нөхцөл бүхий сургууль, анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлнэ. | жилдээ | П.Цагаан<br>Ц.Баярсайхан<br>Ч.Улаан |
| | -Төрөөс суралцагчдад үзүүлж байгаа сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн тогтолцоог шинэчилнэ. | II-III улирал | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Оюутнуудад зориулан оюутны байр, хотхон байгуулах санаачилгыг болон хотхоны хэлбэрээр үйл ажиллагаагаа цогц явуулах их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг дэмжинэ. | жилдээ | П.Цагаан<br>Ц.Баярсайхан<br>Н.Батбаяр |
| | -Сурлагын өндөр амжилт байнга үзүүлсэн, авъяас чадвартай хүүхдүүдэд дэмжлэг, тэтгэлэг үзүүлэх сан байгуулна. | жилдээ | П.Цагаан |
| | - Технологи, инженер, байгалийн шинжлэлийн чиглэлээр гадаадын өндөр хөгжилтэй орнуудад залуу эрдэмтдийг бэлтгэхэд түлхүү анхаарахын зэрэгцээ гадаадын нэр хүндтэй их сургууль, коллежийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсрол экспортлох санаачилгыг дэмжинэ. | жилдээ | П.Цагаан |
| 3.Соёл, урлагийг хөгжүүлэх хөхиүлэн дэмжих шинэ бүтээл туурвих тэдгээрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд | -Хот, суурин газруудад иж бүрэн үйлчилгээ бүхий номын өргөө байгуулах санаачилгыг дэмжинэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Үндэсний дурсгалт соёлын өв хөрөнгийн талаархи мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр боловсруулан ажиллана. | жилдээ | П.Цагаан |
| | -Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, өвлөн уламжлах, сурталчлах ажлыг өргөжүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Музейг мэдээлэл, танин мэдэхүйн эх сурвалж болгохын зэрэгцээ аялал жуулчлал татахад өргөнөөр ашиглахыг дэмжиж музейн сан хөмрөгийг баяжуулах, дохиоллын системд хамруулах ажлыг зохион байгуулна. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Хөдөөгийн соёл, урлагийн байгууллагын барилгыг шинэчлэх, засварлах, болон эдгээр байгууллагыг хөгжмийн зэмсэг, техник хэрэгслээр хангах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, үйлчилгээний хүрээг өргөтгөнө. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Соёл, урлаг, утга зохиолын ажилтан, уран бүтээлчдийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, сургалтад хамруулах, олон улсын наадам, уралдаан, тэмцээнд оролцуулах арга хэмжээг өргөжүүлнэ. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Монголын түүх, урлаг, утга зохиол судлалыг өргөжүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Монголын соёлын өдрүүд, үзэсгэлэнг гадаад орнуудад зохион байгуулна. | жилдээ | П.Цагаан |
| | -Монгол хэл бичгээ судлах, зүй зохистойгоор өвлөх ажлыг хэрэгжүүлж эхлэнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Дэлхийн сонгодог болон үндэсний урлаг, хүүхдийн танин мэдэхүй, боловсролыг хөгжүүлэхэд чиглэсэн урлагийг дэмжинэ. | жилдээ | П.Цагаан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ | жилдээ | П.Цагаан |
| | -Олимп, дэлхий, тивийн хэмжээнд амжилт гаргах магадлалтай спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлнэ. | I-II улирлаас | Т.Ганди |
| 4.Шинжлэх ухаан, технологийн дэвшлийг эдийн засгийн хөгжилд ашиглах, оюуны шинэ бүтээлийн эрэлтийг нэмэгдүүлэн түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилтын хүрээнд | -Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулна. | жилдээ | П.Цагаан |
| | -Шинжлэх ухаан, технологийн үндэсний чадавхийг улс орны хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн улс орны хөгжилд бодитой нөлөө үзүүлж чадах судалгаа, шинжилгээний ажлын чиглэлийг нарийвчлан тогтоож, эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийн механизмийг боловсронгуй болгоно. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | жилдээ | П.Цагаан |
| | -Дотооддоо баталгаажсан шинэ бүтээл, оюуны өмчийг гадаад, дотоодын зах зээл дээр найдвартай хамгаалах тогтолцоо бий болгох санал боловсруулан мөрдүүлж эхлэнэ. | жилдээ | Ч.Улаан |
| | -Бизнесийн захиалгат судалгааны ажлыг дэмжинэ. Шинэ зах зээл нээх, уламжлалт зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлнэ. | жилдээ | Ч.Улаан<br>П.Цагаан<br>С.Батболд |
| | -Шинжлэх ухааны байгууллагуудад 2005 оноос улсын захиалгаар хийгдэх урт, богино хугацааны төслүүдийн үр дүнг тооцох тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн өөрчилнө. | жилдээ | П.Цагаан<br>Н.Алтанхуяг |
| | -Ган, хүйтэнд тэсвэртэй үр тариа, тэжээлийн таримлыг нутагшуулах, шинэ сорт бий болгох, онош нь тогтоогдоогүй зарим өвчний шалтгааныг тогтоох, эмчлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва<br>П.Цагаан |
| | -Монгол малын удам зүйн үзүүлэлтийг шинэчлэн тодорхойлж, ган, зудыг тэсвэрлэх чадвар, ашиг шимийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, селекц, генетикийн аргыг боловсруулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва<br>П.Цагаан |
| | -Олон улсын стандартад нийцсэн малын халдварт өвчний хяналтын системийг нэвтрүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Үйлдвэрлэгчийн захиалгаар шинжлэх ухаан, технологийн төслийг тухайн аж ахуйг түшиглэн хэрэгжүүлж, үр дүнг хамтран нэвтрүүлэх хэлбэрийг туршина. | жилдээ | П.Цагаан |
| 5.Эрүүл мэндийн салбарт орчин үеийн дэвшилтэт оношлогоо, эмчилгээний арга, технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэх ажлыг иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурлан сайжруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалж, бэхжүүлэх зорилтын хүрээнд | -Орчин үеийн иж бүрэн оношилгооны төвийг нийслэл, бүсийн төвүүдэд байгуулах ажлыг эхлүүлнэ. | жилдээ | Т.Ганди<br>Н.Алтанхуяг |
| | -Эрүүл мэндийн үйлчилгээнд эрхийн бичгийн системийг нэвтрүүлэх боломжийг судална. | жилдээ | Т.Ганди |
| | -Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нийцүүлэн эрүүл мэндийн салбарт бүтээгдэхүүнд тулгуурлан төсөвлөх бэлтгэл ажлыг эхлүүлж хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Ганди<br>Н.Алтанхуяг |
| | -"Мянганы тунхаглал"-ын зорилтыг хангахын тулд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа алслагдсан нутгийн хүн ам, шилжин иргэдэд хүргэх тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна. | жилдээ | Т.Ганди |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Эхийн эндэгдлийг бууруулах 2005-2010 оны стратегийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ | жилдээ | Т.Ганди |
| | -Эрүүл мэндийн даатгалын системийг боловсронгуй болгоно. | жилдээ | Т.Ганди Ц.Баярсайхан |
| | -Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтыг сайжруулж, олон улсын жишиг хангахуйц техникийн боловсролтой сувилагч, эмнэлгийн дунд мэргэжилтнийг шинээр бэлтгэх бодлогын болон эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Сумын эмнэлгийн хөтөлбөрийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр сумдын эмнэлгийн чадавхийг сайжруулна. | жилдээ | Т.Ганди |
| | -Хавсарсан вакцинуудыг дархлаажуулалтад нэвтрүүлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Хүний дархлал хомсдолын вирус, ДОХ, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөжүүлж, бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэлт, эмчилгээ, оношилгоог сайжруулна. | жилдээ | Т.Ганди |
| | -Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, халгаат хүчин зүйлийг тандах, хяналт тавих нэгдсэн хөтөлбөр боловсруулж нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээг сум, өрхийн эмнэлгийн түвшинд нэвтрүүлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Эрүүл мэндийн салбарт хөдөлмөрийн үнэлэмж, төлбөртэй уялдсан үйл ажиллагааны стандартыг тогтоон эмч, ажиллагсдын бодит орлогыг нэмэгдүүлнэ. | жилдээ | Т.Ганди Ц.Баярсайхан |
| | -Эмч, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын ёс зүйн хэм хэмжээг боловсруулж, дагаж мөрдөх журам батлан хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Иргэд хүрээлэн буй орчин, эрүүл ахуйн талаарх мэдээллийг чөлөөтэй олж авах, эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, био бэлдмэлийг зөв хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх мэдээллийг өөрсдийн эрүүл мэндтэйгээ холбон ойлгох, эрүүл ахуйн шаардлагаа хангуулах талаар шаардлага тавих чиглэлээр мэдлэгтэй болгоход иргэдэд мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. | жилдээ | Т.Ганди Б.Барсболд |
| | -Ундны усны стандартыг баталж мөрдүүлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Замын-Үүдийн чөлөөт бүсийн хэрэглээний болон ундны усан хангамжийг шийдвэрлэнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Эрүүл мэндийн үйлчилгээний чирэгдлийг багасгах, ачааллыг жигд хуваарилах, яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлэх, нас баралтыг багасгахад чиглэсэн эмнэлэг, эмнэлэг дундын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулахыг дэмжинэ. | жилдээ | Т.Ганди Н.Алтанхуяг |
| | -Олон улсын хөл хориот өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүн амыг хамгаалахад чиглэсэн явуулын лаборатори, оношилгоо, эмчилгээний багуудын чадавхи болон гамшгийн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, мэдээлэх тогтолцоог сайжруулна. | жилдээ | Т.Ганди |
| | -Халдварт өвчнөөс сэргийлэх эм тарилга, вакцины нөөцийг бүх түвшинд бүрдүүлж, чанарыг алдуулахгүй хүн амд түгээх тусгай хэрэгслийн хангалтыг сайжруулна. Эрүүл хүүхдэд хийх тарилгын тоог цөөрүүлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Зүрх, судасны өвчин, хорт хавдар, ослоос шалтгаалсан нас баралтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Ганди |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Эрүүл аж төрөхөд чухал шаардлагатай явган хүний гүйлтийн болон унадаг дугуйн зам, нээлттэй орон зай, талбай, ногоон бүс, тахир дутуу иргэдэд зориулсан дэд бүтцийг тусгах ажиллагааг хот төлөвлөлтийн зайлшгүй элемент болгож, уг талбайд шаардагдах газрыг өөр зориулалтаар ашиглуулахаар олгохыг хязгаарлана. | жилдээ | Н. Батбаяр |
| | -Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэнд, хөгжлийг хамгаалах, дэмжих, зонхилон тохиолдох өвчин эмгэгүүд болон хоол, тэжээлийн байдлын талаарх судалгаа хийж, гэнэтийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний болон олон улсын хөтөлбөрүүдийн уялдааг боловсронгуй болгоно. | жилдээ | Т.Ганди<br>Ч.Улаан |
| | -Жирэмсэн эхчүүд болон бага насны хүүхдийг шимт бодис, амин дэм, бичил элементийн дутлаас сэргийлэх зорилгоор хоол тэжээлийн үндэсний стратеги боловсруулан хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Ганди<br>Ч.Улаан |
| | -Үндэсний фармакопейн өгүүллүүдийг боловсруулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | Т.Ганди |
| | -Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношилгоо, эмчилгээг сайжруулах зорилгоор эмнэлгийн тусламжийн шатлалд тохирсон оношилгоо, эмчилгээний стандарт, клиникийн удирдамж боловсруулан мөрдөнө. | жилдээ | Т.Ганди |
| | -Эм хангамжийн байгууллагууд, эмийн үйлдвэр, эмийн сан, гоо сайхны болон бялдаржуулах үйлчилгээ, уламжлалт анагаах ухааны стандартыг боловсруулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Гамшгийн үед эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог сайжруулна. | жилдээ | Т.Ганди |
| | -Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн менежментийг боловсронгуй болгоно. | жилдээ | Т.Ганди |
| | -Эмнэлгийн түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Ганди |
| | -Хэнтий аймгийн Өндөрхаан хотод спортын цогцолбор байгуулна. | жилдээ | Т.Ганди |
| | -Нийтийн биеийн тамирын үндэсний тогтолцоог бүрдүүлэх цогц арга хэмжээ авч эхэлнэ. | жилдээ | Т.Ганди |
| 6.Нийгмийн даатгалын төрөл, сонголтыг нэмэгдүүлэх, нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдах баталгаар сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн ажилгүйдэл ядуурлыг багасгах зорилтын хүрээнд | -Ажил олгогчид ногддог татвар, шимтгэлийн ачааллыг тооцоолж, хөдөлмөрийн багтаамж ихтэй үйлдвэрлэлийг дэмжих замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | I-II улирал | Ц.Баярсайхан |
| | -Ажиллах хүчний бүтээмж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтад онцгой анхаарна. | | |
| | -Хүүхдэд төрсөн цагаас нь иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дугаар олгох эрх зүйн орчныг бүрдүүлж уг ажлыг эхлүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Ц.Нямдорж |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын одоогийн тогтолцоог боловсронгуй болгохын зэрэгцээ хувийн нэмэгдэл даатгалын тогтолцоог бий болгох, нийгмийн даатгалд гэр бүлийн хүлээх сайн дурын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хамрах хүрээг өргөжүүлж, нийгмийн баталгааг сайжруулна. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Говийн аймагт ажиллаж байгаа эмч, багш нарт говийн нэмэгдэл олгох асуудлыг судлах ажлыг эхлэнэ. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -1995 оноос өмнө болон хойно тогтоосон тэтгэврийн зөрөөг арилгахад чиглэсэн судалгааг хийж, авах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | -Аймгийн болон бүсийн төвүүдэд ахмад настан, тахир дутуу иргэдийг асран сувилах үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн хэлбэрээр зохион байгуулна. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Өндөр настны нийгмийн хамгааллыг сайжруулахын зэрэгцээ тэднийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах арга хэмжээг зохион байгуулж буй аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нийгмийн санаачлагыг дэмжинэ. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, төрийн албан хаагчдын болон төсөвт байгууллагад ажиллагсдын үндсэн цалингийн хэмжээг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан 7,5-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | -Нийгмийн хамгааллын үйлчилгээг нийгэм, хамт олонд түшиглэсэн хэлбэрээр хөнгөн шуурхай, уян хатан хүргэх үүрэг бүхий нийгмийн үйлчилгээний төвийг бүсийн төвүүд болон нийслэлийн зарим дүүрэгт туршин ажиллуулна. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Ч.Улаан |
| | -Ажилтны мэргэжлийн ур чадварыг харилцан зөвшөөрөх, магадлан итгэмжлэх, үнэмлэхжүүлэх болон ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөх гэрээ, хэлэлцээрийг сонирхсон орнуудтай байгуулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аж ахуйн нэгжийн оролцоотой үндэсний мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдыг хэтийн төлөвийн дагуу бэлтгэх, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэн 37000-аас доошгүй ажлын байрыг шинээр бий болгоно. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх хөдөлмөрийн бирж, мэдээллийн төвүүдийг холбосон мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулна. | жилдээ | Ц.Баярсайхан<br>С.Баярцогт |
| | -Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг гаргах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийг нэвтрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажил олгогчид болон ажилчлагсдын идэвхтэй оролцоотойгоор хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Ц.Нямдорж |
| | -Гадаадад хөдөлмөр эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно. Тэдэнд төрөөс үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлж зуучлах үйлчилгээнд төрийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Ц.Мөнх-Оргил<br>Ц.Нямдорж |
| | -Ажиллагсдад эрхээ хамгаалуулахад дэмжлэг үзүүлж, хөдөлмөрийнхөө үр шимийг шударга хүртэх боломжийг нэмэгдүүлнэ. Үйлдвэрчний эвлэлийн болон эздийн байгууллагатай хамтран нийгмийн түншлэлийн харилцааг хөгжүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан |

| 1 | 2 | 3 | 4 |
| --- | --- | --- | --- |
| | -Албадлагын хөдөлмөрийг устгах асуудлаар олон улсын хөдөлмөрийн байгууллагын холбогдох конвенцид нэгдэн орж, түүнийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Ц.Мөнх-Оргил |
| | -Нийгмийн халамжийн тогтолцоонд өөрчлөлт хийх асуудлыг судлан шийдвэрлэж, нийгэм, хамт олонд түшиглэсэн халамж, үйлчилгээний шинэ хэлбэрийг турших замаар нийгмийн халамжид хамрагдах шалгуур үзүүлэлт, өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгоно. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Н.Алтанхуяг |
| | -Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр эрт тэтгэвэрт гарах даатгуулагчдад зориулсан тэтгэврийн даатгалын хөтөлбөр боловсруулна. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. | I-II улирал | Ц.Баярсайхан |
| | -Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын систем нэвтрүүлэх асуудлыг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Бичил аж ахуйн нэгжийг дэмжин туслах зорилгоор зарим аймагт бизнесийн хөгжлийг дэмжих инкубаторын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Албан бус салбарт ажиллагсдын эдийн засаг, нийгмийн асуудлаар төрийн бодлогыг боловсруулна. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Хүүхдийн хөдөлмөрийг хориглох болон түүнийг урьдчилан сэргийлэх талаар олон улсын хөдөлмөрийн байгууллага, хандивлагч бусад орны туслалцаатайгаар хамтарсан төсөл хэрэгжүүлнэ. | жилдээ | Ч.Улаан<br>Ц.Баярсайхан |
| | -Малчид, хөдөөгийн хөдөлмөр эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн мэргэжлийн ур чадварын болон аж ахуй эрхлэлтийн сургалтыг зайны сургалтын хэлбэрээр хөгжүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | -Хоршоо, нөхөрлөл байгуулах, хамтын хөдөлмөр, аж ахуй эрхлэхэд зориулан иргэдэд зээл тусламж олгох, хөрөнгийн эх үүсвэрээр дэмжих замаар ажлын байраар хангах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | Ц.Баярсайхан |
| | **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | |
| 1.Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах зорилтын хүрээнд | -Эдийн засгийн бодит өсөлтийг 7.0 хувьд хүргэнэ. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | -Инфляцийн түвшинг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байлгах зохицуулалтын арга хэмжээ авна. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүдтэй уялдуулан төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн харьцангуй тогтвортой байдлыг хангана. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Төсвийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 3.5 хувиас хэтрүүлэхгүй байлгана. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | -Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг нэг шатлалд шилжүүлэх нөхцөл бүрдүүлнэ. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | -Импортын татварын зохистой бодлого баримталж, дотоодын зах зээлийг хямралаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. | жилдээ | Н.Алтанхуяг |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Малын тоо толгойг өсгөх, мал аж ахуйг бизнесийн хэв шинжтэй салбар болгох, малчдын амьжиргааны түвшинийг дээшлүүлэх зорилгоор малчдын мал бүхий иргэний албан татвараас чөлөөлөх асуудлыг судална. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | -Зээл, тусламжийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авна. | жилдээ | Н.Алтанхуяг<br>С.Батболд |
| | -Шударга бус өрсөлдөөнийг хориглох, дангаар ноёрхохыг хязгаарлах үр дүнтэй тогтолцоог бий болгоно. | I улирал | Ч.Улаан |
| | -Дампуурал, шударга бус өрсөлдөөнийг хориглох болон тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчны шинэтгэлийг гүнзгийрүүлэх арга хэмжээ авна. | I улирал | Ч.Улаан<br>Ц.Нямдорж |
| | -Эдийн засгийн загварыг боловсруулах судалгааны ажлыг эхлүүлнэ. | жилдээ | С.Батболд |
| | -Сүүдрийн эдийн засгийг албажуулах арга хэмжээ авна. | жилдээ | П.Бямбацэрэн<br>Н.Алтанхуяг |
| 2.Банк, санхүүгийн салбарыг бэхжүүлэх зорилтын хүрээнд | -Санхүүгийн зах зээл, зуучлалын үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээ авч эхэлнэ. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | - Засгийн газрын бондыг Олон улсын санхүүгийн зах зээлд гаргах бэлтгэлийг хангана. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | -Санхүү мөнгөний таатай, өрсөлдөх чадвар бүхий бүсүүдийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | жилдээ | Ч.Улаан<br>Н.Алтанхуяг |
| | -Урт хугацааны зээл, ипотекийн аргыг нэвтрүүлэх замаар иргэдийг орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлнэ. | жилдээ | О.Чулуунбат<br>Н.Батбаяр |
| | -Ипотекийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийг бий болгоно. | жилдээ | С.Гүндэнбал<br>Н.Алтанхуяг |
| | -Зээлийн хүүг бууруулахад мөнгөний бодлогоор нөлөөлж, эдийн засгийн эрчимтэй үйл ажиллагаа явуулах боломжоог иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгоно. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, үнэт цаасаар хөрөнгө оруулах ажлыг дэмжих зорилгоор үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ. | жилдээ | С.Гүндэнбал |
| | -Үнэт цаасны зах зээлд оролцогчдын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тогто | жилдээ | С.Гүндэнбал<br>Н.Алтанхуяг |
| | -Төлбөр тооцоог бэлэн бусаар болон электрон хэлбэрээр хийх боломж өргөтгөнө. | жилдээ | О.Чулуунбат |
| | -Иргэний хувийн дансны нууцлалыг чангатгаж хувийн дансны нууцлалыг онцгой, өндөр нөхцөлөөр хуульчлан хамгаална. | жилдээ | О.Чулуунбат<br>Ц.Нямдорж |
| | -Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой банкуудыг хувьчлах ажлыг үргэлжлүүлж, Хадгаламжийн банкийг хувьчилна. | жилдээ | Н.Алтанхуяг<br>О.Чулуунбат |
| | -Хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэрийг дайчлах, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хөрөнгийн биржийн үйл ажиллагааг сэргээх арга хэмжээ авна. | жилдээ | С.Гүндэнбал<br>Н.Алтанхуяг |
| | -Дэлхийн банкны техник туслалцааны төслийн хүрээнд малын даатгалын салбарт эрх зүйн зохицуулалт шаардлагатай эсэх талаар судалгаа хийнэ. | жилдээ | Н.Алтанхуяг<br>Д.Тэрбишдагва |
| | -Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны эрсдлийг бууруулахад даатгалын механизмыг ашиглах боломжийн талаар судалгаа хийж, санал боловсруулна. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | -Лизингийн тухай хуулийн төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | жилдээ | Н.Алтанхуяг<br>Ц.Нямдорж |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 3.Хувьчлалыг үргэлжлүүлж, газар болон өмч хөрөнгийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд | -Газрын шинэтгэлийг эрчимжүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Газрын өмчлөлийн мэдээлэл, бүртгэлийг иргэдэд нээлттэй байлгах техникийн бэлтгэлийг хангана. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Үл хөдлөх хөрөнгийн байршил, аж ахуйн нэгжийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгоно. | жилдээ | Н.Батбаяр<br>Н.Алтанхуяг |
| | -Газрын байршлын нэгдсэн кодод шилжинэ. Байршлын кодоор дамжуулан үл хөдлөх хөрөнгийн үнэлэмжийг тогтооно. | жилдээ | Н.Батбаяр<br>Н.Алтанхуяг |
| | -Үл хөдлөх хөрөнгийн татварыг боловсронгуй болгоно. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | -Газрын төлбөрийн хэмжээг газрын үр өгөөж, байршилтай уялдуулж ялгавартай тогтооно. | жилдээ | Н.Алтанхуяг<br>Н.Батбаяр |
| | -Хувьчлалын арга хэлбэрийг өргөтгөж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. Үнэ цэнэ бүхий томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Н.Алтанхуяг |
| | -Нийгмийн салбарт хувьчлал хийх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Баярсайхан<br>Т.Ганди<br>П.Цагаан |
| | -Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах замаар төвлөрлийг бууруулж, ил тод байдлыг нэмэгдүүлнэ. | жилдээ | Н.Алтанхуяг<br>Ц.Нямдорж |
| 4.Үйлдвэрлэл, уул уурхай, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд | -Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулах бодлогыг үргэлжлүүлж өргөтгөнө. | жилдээ | Ч.Улаан<br>С.Батболд |
| | -Төрөөс үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого боловсруулахад мэргэжлийн холбоодын идэвхтэй оролцоог хангах механизм бий болгоно. | жилдээ | С.Батболд |
| | -Зарим аймаг, хотод үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэлийг хангана. | жилдээ | С.Батболд |
| | -Экспортын чиглэлийн болон оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэлийг дэмжинэ. | жилдээ | С.Батболд |
| | - Засгийн газрын захиалгат бараа, бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална. | жилдээ | С.Батболд<br>Н.Алтанхуяг |
| | -Орон нутагт үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хоршоодын үйл ажиллагааг дэмжсэн тогтолцоог боловсронгуй болгоно. | жилдээ | С.Батболд |
| | -Фермерийн болон эрчимжсэн хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Хөдөө орон нутагт бичил зээл олгох тогтолцоог бий болгон хөгжүүлнэ. | жилдээ | С.Батболд<br>Ц.Баярсайхан<br>Д.Тэрбишдагва |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Жижиг, дунд үйлдвэр, газар тариалан, фермерийн аж ахуйг дэмжих зорилгоор жижиг зээлийн үйлчилгээний хүрээг өргөтгөж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хөдөө аж ахуйн техник, төхөөрөмжийг урт хугацаатай, бага хүүтэй зээл, түрээс, лизингээр олгох болон төлбөрт үйлчилгээний хэлбэрийг дэмжиж, боловсронгуй болгоно. | жилдээ | С.Батболд Д.Тэрбишдагва |
| | -"Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлж, чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүнийг шинээр бий болгож гадаад, дотоодын зах зээлд гаргахыг дэмжинэ. | жилдээ | С.Батболд Д.Тэрбишдагва |
| | -Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа бүс нутгуудад зохиомол хээлтүүлгийн байнгын болон явуулын цэг байгуулан үйлчилгээг өргөтгөнө. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлж, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах олон улсын зөвлөмж, стандартыг үндэсний болгон хүлээн зөвшөөрч, экспортын нэр төрлийг нэмэгдүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Өндөр ашиг шимтэй үүлдэр, омгийн малын цөм сүрэг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Сүү боловсруулах орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжинэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Дотоодын зах зээлд борлуулах махны стандартыг шинэчлэн мөрдүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Ховордож байгаа үүлдэр, омгийн мал, тэжээвэр амьтны үрийг малын удмын сангийн үндэсний төвд хадгалах ажлыг зохион байгуулна. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Гойд ашиг шимт үржлийн мал шалгаруулах үзэсгэлэн, худалдааг бүсчлэн зохион байгуулна. | II-III улирал | Д.Тэрбишдагва |
| | -Усалгаатай тариалан эрхлэх, тариаланчдад газар өмчлүүлэхийг дэмжинэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Төмс, хүнсний ногоо, хүнс, тэжээлийн үет буурцагт ургамал болон жимс, жимсгэний үйлдвэрлэлийг дэмжинэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Гадаад орон, олон улсын байгууллагаас хүнсний хангамж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр олгосон буцалтгүй тусламжийн хуримтлалын санг усалгаатай тариаланг хөгжүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, хүнсний буудайн болон гурилын хангамжийг сайжруулах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн эх үүсвэр болгон ашиглах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва Н.Алтанхуяг |
| | -Бэлчээрийн менежмент, мал эмнэлэг, үржлийн ажлыг сайжруулж, малын даатгалын системийг нэвтрүүлэх замаар уламжлалт мал аж ахуйн байгалийн эрсдэлийг давах чадварыг дээшлүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Геологийн зураглал, геофизикийн хүндийн хүчний орны судалгаа, ашигт малтмалын ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | С.Батболд |
| | -Усан хангамжийг сайжруулах үүднээс газрын доорх усны эрэл хайгуулыг үргэлжлүүлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Хулдаг усны хангамжийг сайжруулж, бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх, хортон мэрэгчидтэй тэмцэх ажлын арга барилыг боловсронгуй болгоно. Энэ чиглэлээр гадаад орнуудын туршлагыг судалж нэвтрүүлнэ. | жилдээ | У.Барсболд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Малын гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалт хийнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Үхрийн мялзан өвчний тандан судалгааг нарийсган хийж, Олон улсын мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын түвшинд Монгол Улсыг уг өвчний халдваргүй орны жагсаалтад орох бэлтгэлийг хангана. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Усалгаатай талбайн хэмжээг өргөтгөх, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Гурил, төмс, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногооны зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг татварын бодлогоор зохицуулах замаар дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва<br>Н.Алтанхуяг<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга нар |
| | -Төмөртийн Овооны цайр, Тавтын алт, Төмөртэйн төмрийн хүдэр, Эрдэнэтийн молибдены баяжмал боловсруулах үйлдвэрүүд болон томоохон орд газрыг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | С.Батболд |
| | -Газрын тосны эрэл хайгуулын судалгаа болон олборлолтыг эрчимжүүлнэ. | жилдээ | С.Батболд |
| | -Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар санал боловсруулж, холбогдох арга хэмжээг авна. | жилдээ | С.Батболд |
| | -Нүүрсний гүн боловсруулалтын судалгаа хийж, хөтөлбөр хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Очирхүү<br>С.Батболд |
| | -Шингэрүүлсэн түлш, байгалийн хийг ахуй болон үйлдвэрлэл, тээвэрт ашиглах ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулна. | жилдээ | Т.Очирхүү<br>С.Батболд |
| | -Эрчим хүчний хэмнэлтийн эрх зүйн орчныг бий болгоно. | жилдээ | Т.Очирхүү<br>Ц.Нямдорж |
| | -Хөдөө орон нутгийн нүүрсний хангамжийг сайжруулах арга хэмжээ авна. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Ховд, Сүхбаатар аймгийн нутагт нүүрсний хайгуул хийх зэрэгцээ түлшний асуудлыг шийдэх арга хэмжээ авна. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Уул уурхайн ашигт малтмалын ордыг ашиглахдаа тухайн орон нутгийн хүн амын ахуй амьдралыг сайжруулах зорилттой уялдуулна. | жилдээ | С.Батболд |
| | -Гадаад, дотоодын хүч хөрөнгөөр хийх геологийн зураглал, хайгуулын ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | С.Батболд<br>У.Барсболд |
| 5.Хөрөнгө оруулалтыг хамгаалсан найдвартай орчныг бий болгох зорилтын хүрээнд | -Гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтыг урамшуулсан бодлого хэрэгжүүлнэ. | жилдээ | С.Батболд<br>Н.Алтанхуяг |
| | -Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого явуулна. | жилдээ | С.Батболд<br>Н.Алтанхуяг |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Дэд бүтцийн салбарт хувийн шууд хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | жилдээ | С.Батболд Н.Батбаяр Т.Очирхүү Г.Батхүү |
| | - 2005 оны хөрөнгө оруулалтыг 2004 оныхоос нэмэгдүүлнэ. | жилдээ | С.Батболд Н.Алтанхуяг |
| 6.Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөхүйц дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэх зорилтын хүрээнд | -Дулааны цахилгаан станцуудын шинэчлэлт, цахилгаан шугам сүлжээний алдагдлыг багасгах төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Тээврийн салбарын хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлж эхлэхийн хамт замын сангийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | жилдээ | Г.Батхүү Ц.Нямдорж |
| | -Орхон аймгийн Дулааны цахилгаан станцын өргөтгөлийг олон улсын төслөөр хэрэгжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Төмөр замын тээврийн сүлжээг өргөжүүлэн тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын тээвэрт төмөр замын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | Г.Батхүү |
| | -Ойрын 2 жилд 11 өртөө, зөрлөгийг шинээр барьж, 17 илчит тэргэнд өөрийн хүчээр техник технологийн иж бүрэн шинэчлэл хийж, удирдлага мэдээллийн системийг иж бүрэн автоматжуулна. | жилдээ | Г.Батхүү |
| | -Хос төмөр замтай болгох, төмөр замыг цахилгаанжуулах ажлын судалгаа хийж эхэлнэ. | жилдээ | Г.Батхүү С.Батболд Т.Очирхүү |
| | -Таван толгой, Оюу толгой, Цагаан суварга, Асгатын болон бусад томоохон ордыг ашиглах дэд бүтцийг байгуулах ажлыг олон талын оролцоотойгоор шийдвэрлэх асуудлыг судалж эхэлнэ. | | С.Батболд Г.Батхүү Т.Очирхүү Н.Алтанхуяг У.Барсболд |
| | -Эрчим хүч, авто зам, харилцаа холбоо, мэдээллийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Очирхүү Г.Батхүү |
| | -Тээврийн хэрэгслээс авах хураамжаас бүрдэж буй замын санг Авто замын тухай хуульд заасны дагуу төсөвт төвлөрүүлж, Засгийн газрын шийдвэрээр зарцуулдаг болгоно. | жилдээ | Г.Батхүү Н.Алтанхуяг |
| | -Зүүн бүсийн эрчим хүчний системийг төвийн эрчим хүчний системд холбох ажлын хүрээнд Баруун-Урт-Өндөрхааны 110 квт-ын шугамыг барьж эхэлнэ. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, олон улсын томоохон нисэх буудал шинээр барихыг дэмжинэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Далайн тээврийн зарим конвенцид нэгдэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авч, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| 7.Аялал жуулчлалын болон мэдээлэл, харилцаа холбоо, технологийг хөгжүүлэх зорилтын хүрээнд | -"Цахим Монгол" хөтөлбөрийг боловсруулж, эхний үе шатыг хэрэгжүүлж эхэлнэ. | жилдээ | С.Баярцогт |
| | -Төмөр замын шилэн кабелийг Орос, Хятадаар дамжин өнгөрч байгаа олон улсын урсгалд холбох ажлыг эхэлнэ. | жилдээ | С.Баярцогт Г.Батхүү |
| | -Улс орны хэмжээнд нэгдмэл кодчлолыг бий болгосноор мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлж эхэлнэ. | жилдээ | С.Баярцогт |
| | -Цахилгаан холбооны суурь сүлжээг шинэчлэх олон улсын өргөн зурвасны сүлжээнд нэгдэх ажлыг эхлүүлнэ. | жилдээ | С.Баярцогт |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Мэдээллийн технологийн багц хуулийн төслийг боловсруулж батлуулна. | жилдээ | С.Баярцогт<br>Ц.Нямдорж |
| | -Мэдээлэл, холбооны технологийн салбарын бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | жилдээ | С.Баярцогт<br>Ц.Нямдорж |
| | -Томоохон суурин газруудын холбоожуулалтыг өргөтгөх, интернетийн сүлжээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | С.Баярцогт |
| | -Төвийн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хөдөөгийн болон алслагдсан сумын төв, суурин газрын мэдээлэл холбооны сүлжээний шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | жилдээ | С.Баярцогт |
| | -Программ хангамжийн эрэлтийг нэмэгдүүлэх замаар бүтээгдэхүүний өсөлтийг дэмжинэ. | жилдээ | С.Баярцогт<br>С.Батболд |
| | -Томоохон суурин газруудын автомат телефон станцыг тоон технологид үе шаттай шилжүүлнэ. | жилдээ | С.Баярцогт |
| | -Орон нутагт радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн сувгийн тоог нэмэгдүүлж, чанарыг нь дээшлүүлнэ. | жилдээ | С.Баярцогт |
| | -Алсын зайн сургалт, оношилгооны сүлжээ байгуулах чиглэлээр ажиллана. | жилдээ | С.Баярцогт |
| | -Гудамжны нэр, хаягжуулалтын асуудлыг хот, аймгийн төвүүдийн хүрээнд шийдвэрлэнэ. | жилдээ | Н.Батбаяр<br>С.Баярцогт<br>аймаг, нийслэлийн Засаг дарга нар |
| | -Бүх шатны шуудан хүргэлтийн тогтолцоог боловсронгуй болгож, шуудангийн зах зээлийн өрсөлдөөний зохицуулалтын механизмыг бүрдүүлэн шууданд санхүүгийн болон электрон худалдааны үйлчилгээг нэвтрүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Үндэсний соёл, түүх, нүүдэлчдийн амьдралын хэв маягийг тусгасан, жуулчдыг татах төслүүдийг идэвхтэй дэмжинэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Олон улсын түвшинд нийцсэн аялал жуулчлалын цогцолборууд бий болгохыг хөхүүлэн дэмжинэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Жуулчин хүлээн авах байр, жуулчны бааз, жуулчдад зориулсан үйлчилгээнд тодорхой стандарт баталж мөрдүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Жуулчдыг хүлээн авах зочид буудлуудын зэрэглэлийг дээшлүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Аймаг, хот, төвлөрсөн газруудыг аялал жуулчлал хөгжүүлэх тусгай хөтөлбөр, төлөвлөгөө, бүтэцтэй болгоно. | жилдээ | Г.Батхүү |
| | -Дотоодын жуулчлалыг идэвхтэй хөгжүүлж, салбарын үйл ажиллагааны улирлын шинж чанарыг багасгах арга хэмжээг авч эхэлнэ. | жилдээ | Г.Батхүү<br>Т.Очирхүү |
| | -Жуулчдыг татах зорилгоор визийн хялбарчилсан системийг нэвтрүүлэх асуудлыг холбогдох орнуудтай хамтран судалж хэрэгжүүлнэ. | жилдээ | Г.Батхүү<br>Ц.Мөнх-Оргил |
| | -Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг Монгол түмний түүх уламжлалыг сэргээх, аялал жуулчлалын орчин, дэд бүтцийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан зохион байгуулах бэлтгэл хангана. | жилдээ | Г.Батхүү |

| 1 | 2 | 3 | 4 |
| --- | --- | --- | --- |
| 8.Гадаад худалдааны бодлогын хүрээнд | -Экспортыг бүх талаар дэмжиж, түүнд ээлж байгаа ашигт малтмалын хэмжээг бууруулахгүйгээр экспортын төрөлжилтийг нэмэгдүүлнэ. Технологийн хөгжлийн сан байгуулах замаар экспортод гарах шинэ бүтээгдэхүүнийг дэмжинэ. | жилдээ | С.Батболд<br>Н.Алтанхуяг<br>Т.Очирхүү |
| | -Гадаад орнуудтай хөдөлмөрийн зах зээлийг либералчлах, татварын хувь болон гүйлгээний зардлыг бууруулах, худалдааны хориг, саадуудыг багасгах талаар идэвхтэй ажиллана. | жилдээ | С.Батболд<br>Ц.Мөнх-Оргил<br>Н.Алтанхуяг |
| | -Далайд гарцгүй орны хувьд дамжин өнгөрөх тээврийн тарифын хөнгөлөлт эдлэх талаар хөрш орнуудтай хийх гэрээ, хэлэлцээрийг идэвхтэй үргэлжлүүлнэ. | жилдээ | С.Батболд |
| | -Гадаад худалдааны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор зарим гол нэр төрлийн бараа, тухайлбал, нефтийн төрлийн бүтээгдэхүүнээр гадаад, дотоодын зах зээл дээр өрсөлдөөнийг бий болгоно. | жилдээ | С.Батболд |
| | -Гадаад худалдаанд тулгарч байгаа тарифын болон тарифын бус саад, бэрхшээлийг хөнгөвчлөх талаар хоёр талт болон олон талт хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана. | жилдээ | С.Батболд |
| | -Хоёр талын болон бүс нутгийн харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж, улс орнуудтай харилцах дунд хугацааны хөтөлбөр гаргана. | жилдээ | С.Батболд |
| | -Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнчлэлийн болон одоогийн мөрдөж буй худалдааны гэрээ, хэлэлцээрүүдийн давуу талыг бүрэн ашиглана. Өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд экспортлох бараа, бүтээгдэхүүнийг хэмжээ хязгаарлалтгүй, татваргүй нийлүүлэх боломжийг ашиглахын тулд улс орныхоо өнөөгийн хөгжлийн статусыг дэлхийн хэмжээнд шинэчлэн тогтоолгох асуудлыг судалж, боломжтой нөхцөлд хэрэгжүүлнэ. | жилдээ | С.Батболд |
| | - АНУ, БНСУ, Украин, Казахстан, ОХУ зэрэг орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах чиглэлд ажиллана. | жилдээ | С.Батболд |
| | -Монгол уламжлалт бүтээгдэхүүний шинэ гадаад зах зээлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | С.Батболд |
| | -Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний зах зээлд Монгол Улсын ээлж буй байр суурийг хадгалах, нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ. | жилдээ | С.Батболд |
| | -Монгол Улсын эрх зүйн орчин, монголын компани, монгол брэндүүдийг сурталчлах зорилгоор интернэтээр цахим-бизнес форум ажиллуулна. | жилдээ | С.Батболд<br>С.Баярцогт |
| | -Бүтээгдэхүүний стандартыг сайжруулснаар Орос, Хятад орны болон бусад зах зээлтэй худалдааны хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу Монгол Улсын стандартыг бүрэн хүлээн зөвшөөрүүлэх чиглэлээр ажиллана. | жилдээ | С.Батболд |
| | -Хөнгөлөлтийн ерөнхий зарчимд бараа, бүтээгдэхүүн нэмж оруулах талаар Европын Холбоо, АНУ, Япон болон бусад оронтой хийх хэлцлийг идэвхжүүлнэ. | жилдээ | С.Батболд<br>Ц.Мөнх-Оргил |
| | -Алтанбулагийн Худалдааны чөлөөт бүс, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ. | I-IY улирал | С.Батболд<br>Ч.Улаан |
| | -Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс Засгийн газар хоорондын комиссын үйл ажиллагааг улам идэвхжүүлнэ. Холбогдох судалгаануудыг хийж шинэ гадаад зах зээлийг идэвхтэй хайна. | жилдээ | С.Батболд<br>Ц.Мөнх-Оргил |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | **ДӨРӨВ. ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГО** | | |
| 1.Хот төлөвлөлт, хот байгуулалт, газар зохион байгуулалтын шинэтгэл хийж, оршин суугчдын эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд | -Хот байгуулалтын стандарт, холбогдох дүрэм, журмууд гаргаж мөрдүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр Ц.Нямдорж |
| | -Эртний нийслэл Хархорин хотыг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Хот суурин газрын дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан шугам сүлжээнд дэвшилтэт, хэмнэлттэй технологи нэвтрүүлж, хүн амын өсөн нэмэгдэх хэрэгцээг хангана. | жилдээ | Т.Очирхүү Н.Батбаяр |
| | -Хот суурин газрын авто зам, гудамж, талбайн тохижилтод иргэдийн аюулгүй байдлыг хангах стандартыг тогтооно. | жилдээ | Н.Батбаяр Ц.Нямдорж Г.Батхүү |
| | -Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд нийцүүлэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна. | I, II улирал | Н.Батбаяр Ч.Улаан Ц.Нямдорж |
| | -Улаанбаатар хотын Дулааны үр ашгийн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хэрэглэгчдийн 60 хувийг дулаан хангамжийн шинэ системд холбоно. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Архангай, Булган, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн төвүүдийн нийтийн аж ахуйг хөгжүүлэх 2 дахь шатны төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Улаанбаатар хотын гэр хорооллын усан хангамжийг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Улаанбаатар хотын захын ашиглагдаагүй газар талбай дээр амины орон сууцны шинэ хотхонууд байгуулах ажлыг эхэлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Гэр хорооллын айлуудыг цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Орхон аймгийн Хөтөл, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот, Говьсүмбэр аймгийн Чойрын цэвэр усны шугамын шинэчлэлт, Орхон аймгийн Жаргалант сумын цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сайжруулах дэд хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ. | II улирал | Н.Батбаяр |
| | -Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл шинэчлэлийг төслөөр хэрэгжүүлж эхэлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Хот суурин газрын барилга, байгууламжийг хүний аюулгүй байдалд нийцэх, хэрэглээний зориулалтын байдлаар нь үнэлж, тэдгээрт зориулалт тус бүрээр зэрэглэл тогтоох журам бий болгож мөрдөнө. Барилга бүрт зэрэглэл, регистрийн дугаар олгоно. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Орон сууц барих ажлыг эрчимжүүлж, орон сууцны зориулалтаар ашиглаж болох барилгын стандартыг тогтооно. Орон сууцны барилгын гүйцэтгэгч, захиалагч, түрээслэгч нар сууцны барилгын чанар, материалын эрсдэл болон хэрэглээний онцлогийн талаар худалдан авагч, түрээслэгч, хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл олгодог байх шаардлагыг нэвтрүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ. | жилдээ | Н.Батбаяр С.Батболд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Барилгажихад шаардлагатай дэд бүтэц бүхий газар, талбайг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгө болон бизнесийн байгууллагуудын хөрөнгө оруулалтаар орон сууц барьж буй төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Автомашины зогсоолын зориулалт бүхий талбай, тахир дутуу иргэдийн дэд бүтцийн байгууламжийн байрлал, тэдгээрт тавих шаардлагыг хот төлөвлөлтийн орчин үеийн стандартад нийцүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Барилга, хот байгуулалт, газар зохион байгуулалт, газар өмчлөх, эзэмших ашиглах, үнэлэх болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан бий болгож, хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг иргэд чирэгдэлгүй олж авах боломжийг бүрдүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Зах зээлийн харилцааны зарчимд нийцүүлэн үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан орон сууцны урт хугацааны зээлийн бүтэц, тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдэд орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Бүсийн тулгуур төв-Ховд, Улиастай (Баруун бүс), Эрдэнэт, Хархорин (Хангайн бүс), Дархан, Зуунмод (Төвийн бүс), Чойбалсан, Өндөрхаан (Зүүн бүс) хотуудыг шинэчлэгдсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх төсөл, арга хэмжээг дэмжинэ. | I-IY улирал | Ч.Улаан<br>Н.Батбаяр |
| | -Бүсийн тулгуур төвүүд, орон нутгийн хөгжлийн төвүүд, бүлэг суурингийн тогтолцоонд түшиглэн соёл, боловсрол, судалгаа, шинжилгээний байгууллагуудын байршил, шатлал, зэрэглэлийг оновчтой болгох ажлыг дэмжин хэрэгжүүлнэ. | I-IY улирал | Ч.Улаан<br>Н.Батбаяр |
| | -Хайгуул, шинжилгээний ажлын зохион байгуулалтыг орон нутгийн засаг захиргааны ажилтай уялдуулахын хамт, хайгуул, шинжилгээ хийсэн газрыг нөхөн сэргээхэд онцгой анхаарал хандуулна. | жилдээ | С.Батбаяр<br>У.Барсболд |
| 2.Хөдөөгийн дэд бүтэц, харилцаа холбоог бүс нутгийн хэмжээнд хөгжүүлж, орон нутгийн онцлог давуу талыг дэмжих зорилтын хүрээнд | -Газар хувьчлалыг хөдөө орон нутагт зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, газар хувьчлалын эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломжийг хөдөөгийн иргэдэд олгоно. Зах зээлд ойр, замын дагуух газрыг хувьчилна. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Хөдөөгийн газрын харилцааны шинэтгэлд онцгой анхаарч, газрын харилцааны үг зохицуулалтыг нэгдсэн удирдамжаар хангана. | жилдээ | Н.Батбаяр |
| | -Бүс, аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж эхэлнэ. | II-IY улирал | Н.Батбаяр<br>Ч.Улаан |
| | -Бүсийн тулгуур төвүүд, хотжилт явагдаж байгаа газруудын ойролцоо махны чиглэлийн мал сонгон үржүүлж, олон улсын эрүүл ахуй, ариун цэврийн стандартын шаардлагад нийцсэн махыг экспортолно. | жилдээ | Д.Тэрбишдагва<br>Ч.Улаан |
| | -Бүсийн тулгуур төв хотуудын ойролцоо болон газар тариалангийн бүсийг түшиглэн эрчимжсэн мал аж ахуйн сүүний болон гахай, шувууны загвар фермерийн аж ахуйг үүсгэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва<br>Ч.Улаан |
| | -Хөдөөгийн малчин өрх, фермерийн аж ахуй, суурингуудыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах "Буман нарны гэр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Очирхүү |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -2005 онд шинээр цахилгаан дамжуулах шугам, Баян-Өлгийн Алтанцөгц-Ховдын 10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөө, Хөвсгөлийн Мөрөн-Арбулаг-Цагаан-Уул сумдын 35/15 кв-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөө, Үенч-Алтайн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинээр барих болон Дэлхийн банкны шугамын алдагдлыг бууруулах төсөл, Японы хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа ТЭЦ-IV-ийн шинэчлэлийн II шатны төсөл, Эрчим хүчний Нордикийн хөгжлийн сангийн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд Монголын талаас гаргах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Эрчим хүчний нэгдсэн системд холбогдоход хүндрэлтэй төв, суурин газарт нар, салхины эрчим хүч ашиглах судалгаа хийж, Сүхбаатарын Эрдэнэцагааны салхин станц, Хөвсгөлийн Эрдэнэбулган, Завханы Тосонцэнгэл, Ховдын Үенчийн УЦС-ыг барьж ашиглалтад оруулна. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Инженерийн хийцтэй 450 худагт засвар, шинэчлэлт хийж, шинээр 40 худаг гаргах ажлыг говь, тал хээрийн бүсийн аймгуудад төвлөрүүлэн зохион байгуулж, орон нутаг, иргэдийн оролцоотойгоор гар худаг гаргах ажлыг зохион байгуулна. | II-III улирал | Д.Тэрбишдагва |
| | - Тайшир /Улаанбоом/, Дөргөний УЦС, Дөргөн-Мянгад, Тайшир-Улиастай, Арвайхээр-Баянхонгорын хоорондын 110 кв-ын цахилгаан дамжуулах шугамыг барих ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Салхины эрчим хүчний нөөцийг ашиглан боломжтой бүс нутагт бага, дунд хүчин чадалтай салхин парк байгуулах ажлыг зохион байгуулна. | жилдээ | Т.Очирхүү |
| | -Иргэд, залуучуудад бизнес эрхлэхэд нь туслах зорилготой бизнес арилжаа, мэдээллийн төвүүдийг алслагдмал аймаг, хотуудад байгуулахыг дэмжинэ. | жилдээ | С.Батболд |
| | -Бүсийн тулгуур төвүүд болон Увс, Говь-Алтай аймгийн мал эмнэлгийн лабораторийг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Д.Тэрбишдагва |
| | -Баян-Өлгий, Сэлэнгэ, Өвөрхангай, Дорноговь, Сүхбаатар, Говьсүмбэр аймгуудад Бөөний худалдааны сүлжээ байгуулна. | жилдээ | С.Батболд |
| | -"Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хүрээнд мэдээллийн сүлжээ байгуулна. | жилдээ | С.Батболд |
| 3.Хот хөдөөг холбосон зам, гүүр, харилцаа холбооны нөхцөлийг сайжруулж, хөдөөгийн алслагдмал байдлыг багасгах зорилтын хүрээнд | -Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт, холбоо, навигацийн хангалтыг өргөжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Орон нутагт агаарын тээврийн үйлчилгээг өргөжүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Орон нутгийн нисэх буудлуудыг орчин үеийн, ашиглалтын өртөг багатай, бага өврийн онгоц хүлээн авах стандарт, шаардлагад нийцүүлж тоноглоно. | жилдээ | Г.Батхүү |
| | -Орон нутгийн нислэгийн зориулалт бүхий онгоцны паркийг шинэчлэхэд гадаадын болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Мянганы зам барих ажлыг үргэлжүүлж, түүний дагуух гүүр барих, даваа засах ажлыг эрчимжүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Улс, орон нутгийн чанартай зам гүүрийн засвар арчлалтын ажлыг иргэд, аж ахуйн нэгжид гэрээ түрээсээр хариуцуулах замаар ээлтэй болгож, зардал хэмнэн ашиглалтын түвшинг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Төв, Дундговь, Өмнөговийн чиглэлийн авто замын засварын ажлыг нэмэгдүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, замын сүлжээг тойргийн горимд оруулж, гол урсгалуудыг нэг чиглэлтэй болгох арга хэмжээг эхэлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Ховд-Улаангом-Хандгайт, Булган-Ярант, Эрдэнэт-Булган-Уньт, Чойр-Сайншанд-Замын-Үүд, Хархорин-Цэцэрлэг-Тосон цэнгэлийн чиглэлийн хатуу хучилттай авто замыг шинээр буюу үргэлжлүүлэн барина. | жилдээ | Г.Батхүү |
| | -Арвайхээр-Баянхонгор-Говь-Алтай-Ховд чиглэлд хэсэгчилсэн хайрган хучилттай замыг барьж ашиглалтад оруулна. | жилдээ | Г.Батхүү |
| | -Багануур-Өндөрхаан чиглэлийн хатуу хучилттай замыг үргэлжлүүлэн барьж, Ховдын Булган-Ховд, Өндөр хаан-Сүмбэр чиглэлийн зам, гүүр барих бэлтгэлийг хангана. | жилдээ | Г.Батхүү |
| | -Улс хоорондын авто зам барих талаар судалгаа хийх, холбогдох хэлэлцээр, хөрөнгө оруулалт татах ажлыг идэвхжүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Шуудангийн үйлчилгээний автомашины парк шинэчлэлтийг үргэлжлүүлж, бүртгэл тооцооны электрон систем, шуудангийн электрон үйлчилгээг нэвтрүүлж эхлэнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Авто тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношилгооны станцуудын үйл ажиллагааг жигдрүүлж, хот суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна. | жилдээ | Г.Батхүү |
| | -Хөдөө орон нутагт шуудан, зорчигч тээврийн маршрутыг боловсронгуй болгох замаар үйлчилгээний хамрах хүрээ, чанарыг сайжруулж, орлогыг нэмэгдүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Засгийн газраас Азийн хөгжлийн банк, Кувейтын сан болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээний дагуу Эрдэнэт-Булган-Уньтын авто замыг үргэлжлүүлэн барьж, Чойр-Замын-Үүдийн авто замыг эхэлж, Налайх-Чойрын 200 км авто зам, Багануур-Өндөрхаан чиглэлийн авто замын эхний хэсгийг ашиглалтад оруулна. | жилдээ | Г.Батхүү |
| | -Автозамын засвар, арчлалтын ажлын чанар, ашиглалтын түвшинийг дээшлүүлж, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлнэ. | жилдээ | Г.Батхүү |
| | -Даланзадгадын нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасыг барих ажлыг өөрийн хөрөнгө оруулалтаар хийж ашиглалтад оруулна. | жилдээ | Г.Батхүү |
| | **ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО** | | |
| 1.Байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогын уялдааг сайжруулах зорилтын хүрээнд | -Гадаад улс орнууд, олон улсын байгууллагын туслалцаа, дэмжлэгээр шар шорооны нүүдэл, цөлжилттэй тэмцэх иж бүрэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Ойжуулалт, усжуулалтын бодлогыг шинэ түвшинд гаргаж, нутаг орныг ойжуулахад иргэдийн оролцоог үлэмж нэмэгдүүлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Ойг хамгаалахад нутгийн иргэд, нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг тогтмол мэдээллээр хангах замаар ойн сан бүхий газар нутгийн хамгаалалтыг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | II-III улирал | У.Барсболд Ц.Нямдорж |
| | -Ойг нөхөн сэргээх, түүний дагалт баялгийг бүрэн боловсруулж ашиглах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээ авна. | жилдээ | У.Барсболд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Хот суурин газрын орчныг ойжуулах, цэцэрлэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлнэ. | III улирал | У.Барсболд |
| | -Мод, модон материал болон эх орны байгаль экологийн нөхцөлд зохицон амьдрах чадвар бүхий тарьц, суулгацыг импортлох хөнгөлөлттэй нөхцөл тогтоож, үйлдвэрлэлийн зориулалттай модны хэрэглээг импортын модоор хангах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Улын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах "Цагаан тоос" хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулна. | жилдээ | У.Барсболд С.Батболд |
| | -Монгол орны цаг агаар, уур амьсгал, усны нөөц, түүний хувьсан өөрчлөгдөх явц, орчны бохирдолд байнгын хяналт, шинжилгээ хийх, шинжлэх ухаан, техник технологийн дэвшилд тулгуурлан цаг агаарын төлөв байдлыг урьдчилан тодорхойлох ажлыг эрчимжүүлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Хөрс, ус агаар зэрэг хүрээлэн буй орчныг бохирдуулсны хариуцлагын эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, байгаль орчинд хоргүй, утаа багатай хатуу, шингэн хийн түлшний хэрэглээг өргөтгөхөд чиглэсэн аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж, нүүрсээр шахмал түлш хийх үйлдвэр байгуулах зэргээр Улаанбаатар хотын утааны асуудлыг орон нутагтай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | жилдээ | У.Барсболд Т.Очирхүү |
| | -Булаг шандны эх ундаргыг хашиж хамгаалсан гар худаг гарган ашиглах замаар бэлчээр нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоож, хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тогтолцоог бий болгоно. | жилдээ | У.Барсболд |
| | -Усны хатуулаг, эрдэсжилт ихтэй сумын төв, суурин газруудад ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг үргэлжлүүлж, хүн амын ундны усны чанарыг сайжруулна. | жилдээ | Н.Батбаяр Т.Очирхүү |
| | -Байгалийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг арилгах, нөхөн сэргээх чадавхийг нэмэгдүүлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Байгаль хамгаалагч болон байгаль орчны хяналтын улсын байцаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгаа нь хангах эрх зүйн орчныг бий болгоно. | жилдээ | У.Барсболд |
| | -Цаг агаарын эрсдэл, цөлжилтийн эсрэг авах арга хэмжээг эрчимжүүлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Цөлжилтийн эсрэг авч буй арга хэмжээг идэвхжүүлж, энэ чиглэлээр Египет, Казахстан, Иран, Хятад, Энэтхэг зэрэг байгаль цаг уурын ижил төстэй орнуудтай нягт хамтран ажиллана. | жилдээ | У.Барсболд |
| | -Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулахад орон нутгийн иргэдийг татан оролцуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Монгол Улсын нутаг дэвсгэрт буй ашигтай чанар нь мэдэгдсэн, эмчилгээ болон хүнсний зориулалтаар хэрэглэгддэг эмийн ховор ургамал, ургамлын төрөл зүйлийг хамгаалахад анхаарч, таримал байдлаар үржүүлж ашиг, орлого олох боломжийг иргэдэд олгоно. | жилдээ | У.Барсболд |
| | -Үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээг байгаль орчинд халгүй арга, технологиор зохион байгуулна. | II-III улирал | Д.Тэрбишдагва У.Барсболд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Бэлчээрийг хортон мэрэгчдээс хамгаалах, усжуулах ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Ус ашиглалтын хэлбэр, хэрэгцээ, шаардлагыг харгалзан ус хэрэглээний нормыг эдийн засгийн бүс бүрээр, усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг тус тус шинэчлэн боловсруулна. | жилдээ | У.Барсболд |
| | -Хог, хаягдлыг ангилах, ялгах талаар нийслэлийн захиргааны байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж, үүсгэл, санаачилга гаргасан иргэдтэй хамтран ажиллаж, хог хаягдлыг төрөлжүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Хог, хаягдлын менежментийг боловсронгуй болгох" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ. | жилдээ | У.Барсболд<br>Н.Батбаяр |
| | -Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх заавар, журам, аргачлалыг боловсруулан мөрдүүлж, хог хаягдлын эх үүсвэрийг багасгах арга хэмжээ авна. | жилдээ | У.Барсболд<br>Н.Батбаяр |
| | -Бүх нийтэд экологийн боловсрол олгох, байгаль дэлхийгээ хамгаалж ирсэн үндэсний уламжлалыг өвлүүлэх ажлыг өргөн хүрээнд өрнүүлнэ. | жилдээ | У.Барсболд<br>П.Цагаан |
| | -Ус, хөрс, агаарын бохирдлын байдлын тухай статистик мэдээллийг ил тод болгоно. | жилдээ | У.Барсболд<br>П.Бямбацэрэн |
| | -Ус бохирдуулсан этгээдэд хариуцлага ногдуулах хуулийг боловсруулна. | I-II улирал | У.Барсболд<br>Ц.Нямдорж |
| | -Байгаль орчны мэдээллийн санг төрөлжүүлэн баяжуулж, байгалийн нөөцийн мониторинг хийх ажилд орчин үеийн техник, мэдээллийн технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжинэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахад онцгой үүрэг бүхий амьтан, ургамлын зүйлийг судлах, сэргээн нутагшуулах, тарималжуулах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | У.Барсболд |
| | -Байгаль хамгаалал, аялал жуулчлалыг нягт уялдуулах замаар байгалийг байнгын эзэмшил тордолт, хараа хяналттай болгож, нутгийн хүн амд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх, байгалийн аялал жуулчлалыг хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шат дараалсан арга хэмжээ авч эхэлнэ. | жилдээ | У.Барсболд<br>Г.Батхүү |
| | -Байгаль орчны салбарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид болон байгаль хамгаалагчдыг давтан сургаж, мэргэшүүлнэ. | жилдээ | У.Барсболд<br>И.Эрдэнэбаатар |
| | -Уул уурхайн үйлдвэрлэл, ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлон түүнээс урьдчилан сэргийлэх, экологи болон эдийн засгийн үнэлгээний үндсэн дээр хийгдсэн нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг олон нийтэд ил тод болгоно. | жилдээ | У.Барсболд |
| | -Экологийн цэвэр үйлдвэрлэлийн механизмыг хөгжүүлэх тодорхой төслүүдийг хэрэгжүүлнэ. | жилдээ | Т.Очирхүү У.Барсболд |
| | -Гол мөрний сав газрын зөвлөлийг байгуулан ажиллуулах, гол мөрнийг татрах, бохирдохоос хамгаалах арга хэмжээний удирдлагыг сайжруулах ажлыг эхэлнэ. | жилдээ | У.Барсболд |
| | -Эмийн болон хүнсний, түүнчлэн техникийн үнэт ургамлыг нутагшуулах, тарималжуулах замаар үйлдвэрлэлийн түүхий эдийн хэмжээнд ашиглах, унаган болон ховордсон, аж ахуйн чухал ач холбогдол бүхий амьтан, ургамлын гаралтай олзворын зүйлсийг эдийн засгийн хувийн ашиг сонирхлын үүднээс гадаадад гаргахыг хязгаарлах механизмыг бий болгоно. | жилдээ | У.Барсболд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Химийн бодисоос хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллөөс сэргийлэх зорилгоор химийн бодисын улсын тооллого зохион байгуулж, үр дүнг нийтэд мэдээлэн, химийн аюулгүй байдлыг хангах стратегийг боловсруулна. | жилдээ | У.Барсболд |
| | **ЗУРГАА. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО** | | |
| 1.Төрийн цэргийн бодлогын дагуу цэргийн шинэтгэлийн бодлогыг үргэлжлүүлж, орчин үеийн шаардлагад нийцүүлэх зорилтын хүрээнд | -Зэвсэгт хүчний чадавхийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй болно. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд нийцүүлэн зэвсэглэл, техникийг шинэчлэн сайжруулах, цэргийн шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх ажлыг үе шаттай эхлүүлнэ. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, НҮБ-ын Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Зэвсэгт хүчний батальон хилийн чанадад үүрэг гүйцэтгэх явдлыг нэмэгдүүлнэ. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -НАТО-гийн "Энхийн төлөө түншлэл" хөтөлбөрт гишүүнээр элсэхийг эрмэлзэж ажиллана. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -Газрын минийг хориглох Оттавагийн конвенцид үе шаттайгаар нэгдэж, эхний шатанд Монгол Улсын газрын минийн тоо хэмжээ, чанар байдлыг ил тод болгоно. | жилдээ | Б.Эрдэнэбат<br>Ц.Мөнх-Оргил |
| | -Орон нутгийн хамгаалалтын эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлж, эдийн засаг, нийгмийн шинэ нөхцөлд тохирсон улсын болон орон нутгийн дайчилгааны нэгдсэн тогтолцоог бий болгох ажлыг эхэлнэ. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -Цэргийн хөдөлмөрийн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх, Зэвсэгт хүчнийг нийтийн хүч чармайлт шаардсан бүтээн байгуулалтад оролцуулахыг төрийн бодлогоор дэмжинэ. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -Цэргийн байгууллагыг төгөлдөржүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж, Ерөнхий зориулалтын цэргийн үндсэн нэгжүүдийн зориулалт, бүтэц, байршил, хангалтыг аюулгүй байдлын шинэ орчин, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, нутаг орны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж эхэлнэ. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -Зэвсэгт хүчний сургуулийн нэгдсэн төвийг олон улсын хэмжээний төрөл бүрийн цэргийн сургалт явуулах шаардлагад нийцүүлэн үндэсний сургалтын төв болгон өөрчилнө. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -Цэргийн сургалт, бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, энхийг сахиулах, гамшигтай тэмцэх ажиллагаанд бэлтгэхэд сургалтын үйл ажиллагааг чиглүүлж, гэрээт болон дүйцүүлэх албаны тогтолцоог сайжруулна. | жилдээ | Б.Эрдэнэбат |
| | -Цэргийн албан хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх, цэргийн алба хаахтай холбогдсон иргэний харилцааг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулна. | жилдээ | Б.Эрдэнэбат<br>Ц.Нямдорж |
| | -Олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын наймаа, байгаль орчны бохирдол зэрэг аюул заналтай тэмцэх талаар дэлхийн хамтын нийгэмлэгээс тавьж буй хүчин чармайлтад тууштай хувь нэмэр оруулахыг эрмэлзэж ажиллана. | жилдээ | Б.Эрдэнэбат |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| 2.Гамшгаас хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлж, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд | - Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, гамшигтай тэмцэх талаар төрийн байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. | жилдээ | У.Хүрэлсүх<br>Ц.Нямдорж |
| | - Гамшиг судлалын ухааныг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах боловсролыг иргэдэд олгох, мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх тогтолцоог бий болгоно. | жилдээ | У.Хүрэлсүх<br>П.Цагаан |
| | - Гамшгийн мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг боловсронгуй болгож мэдээллийн сан байгуулна. | жилдээ | У.Хүрэлсүх |
| | - Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшгаас хамгаалах үндэсний чадавхийг дээшлүүлэх зорилгоор олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана. | жилдээ | У.Хүрэлсүх |
| | - Гамшгаас хамгаалах ангиудын техник хэрэгслийн хангалт, хүн хүчний бэлтгэл хангамжид онцгой анхаарал хандуулна. | жилдээ | У.Хүрэлсүх |
| | - Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор хөрөнгө, хүчийг захиран зарцуулах оновчтой механизмыг бүрдүүлнэ. | жилдээ | У.Хүрэлсүх<br>Н.Алтанхуяг |
| | - Аврах, гал унтраах ангиудыг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, эрж хайх, аврах чиглэлээр сургаж бэлтгэнэ. | жилдээ | У.Хүрэлсүх |
| | - Улсын болон орон нутгийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршлыг оновчтой болгох саналыг боловсруулна. | жилдээ | У.Хүрэлсүх |
| | - Иргэд, олон нийтэд тулгуурласан гамшгаас хамгаалах менежментийг сайжруулна. | жилдээ | У.Хүрэлсүх |
| | - Хот, суурин байгуулах, бүтээн байгуулалт хийх, орон нутгийн зохион байгуулалтын бүх шатанд гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх нэгдсэн стандарт гаргаж хэрэгжүүлнэ. | жилдээ | У.Хүрэлсүх<br>Н.Батбаяр |
| | - Иргэдийн амь нас, эд хөрөнгийг гамшгаас хамгаалан даатгах тогтолцоог сайжруулж, гамшгийн даатгалын нэр төрлийг олшруулахыг дэмжинэ. | жилдээ | У.Хүрэлсүх<br>Н.Алтанхуяг |
| | **ДОЛОО. ГАДААД БОДЛОГО** | | |
| 1.Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн, бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхитэй явуулж, өөрийн орны язгуур эрх ашиг, түүний дотор иргэд, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг гадаадад тууштай хамгаалж ажиллах зорилтын хүрээнд | -ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагаагаа бүх талаар бэхжүүлж, харилцан тохирсон асуудлуудыг хэрэгжүүлэх, хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд түлхүү анхаарч, өндөр, дээд хэмжээний айлчлалыг хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Худалдааны нэн тааламжтай хөнгөлөлт эдлэх нөхцөлийг худалдааны түнш зарим оронд тавьж шийдвэрлүүлэн, гадаад зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээ авна. Хоёр талын харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж, тодорхой орнуудтай харилцах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Мөнх-Оргил<br>С.Батболд |
| | -Хоёр талаас бэлтгэл нь хангагдаж буй хилийн зарим боомтуудыг байнгын ажиллагаатай болгох арга хэмжээ авна. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, тэдний бодит сонирхлыг Монгол Улсад бий болгох, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өндөр, дээд хэмжээний айлчлалыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Монгол Улс, АНУ-ын хооронд иж бүрэн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлнэ. "Мянганы сорилтын сан"-гаас тусламж авах чиглэлээр ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Иж бүрэн түншлэлийн хүрээнд Япон Улстай улс төр, эдийн засаг, соёлын болон бусад салбарт харилцаа, хамтын ажиллагаар бэхжүүлэх талаар ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Монгол, Европын Холбооны харилцааны түвшнийг ахиулах, Ази, Латин Америкийн хөгжиж буй орнуудын хүрээнд хамтын ажиллагаагаа хөгжүүлж, авч буй тусламжийн хэмжээг бууруулахгүй байх зорилттой ажиллана. Европын Холбооны гишүүн орнуудтай хөгжүүлж ирсэн хоёр талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бататгахын зэрэгцээ хөгжлийн хамтын ажиллагааны хүрээг өргөтгөх чиглэл барин ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Ази, Номхон далайн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхийн зэрэгцээ бүс нутаг, салбар бүсийн хэмжээнд өрнөж байгаа улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн олон талт үйл явц болон яриа хэлэлцээнд оролцож идэвхтэй үйл ажиллагаа явуулна. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -АСЕАН-ийн гишүүн орнуудтай хоёр талын харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэхийг зорино. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -АСЕАН-ийн бүсийн чуулга уулзалт, Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх Зөвлөлгөөн, Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ зэрэг бүс нутгийн олон талт үйл явцын гишүүний хувьд тэдгээрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -АПЕК-ийн ажлын хэсгүүдэд манай улсын оролцоог идэвхжүүлэх чиглэлээр ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Зүүн Хойд Ази, Төв Азийн улс төр, эдийн засгийн үйл явц, яриа хэлэлцээнд идэвхтэй оролцоно. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -"Түмэн гол" төслийн хэрэгжилтийг түргэтгэх чиглэлээр бүсийн хамтын ажиллагаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагаанд ажиглагчийн хувьд оролцоно. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Ази, Европын уулзалтад Монгол Улсыг хамруулах талаар дэмжлэг авах чиглэлээр идэвхтэй ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -НҮБ, түүний системийн болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тэдгээрийн нөөц, боломжийг улс орны аюулгүй байдлыг хангах, нийгэм, эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй ашиглана. "Мянганы хөгжлийн зорилтууд"-ын хэрэгжилтийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганд илтгэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Эвсэлд Үл нэгдэх хөдөлгөөн, 77-гийн бүлгийн үйл ажиллагаанд оролцож, хөгжиж буй орнуудын нийтлэг зорилго болон өөрийн орны үндэсний эрх ашигт нийцсэн асуудлуудаар хамтран ажиллаж, Умард-Өмнөдийн хоорондын яриа хэлэлцээг урагшлуулж, тохиролцоонд хүрэхэд тус дөхөм үзүүлнэ. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын тавдугаар бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Хүний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд терроризм, уламжлалт бус бусад аюул заналтай тэмцэх талаар олон улсын хэмжээнд тавьж буй хүчин чармайлтыг дэмжинэ. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Уламжлалт харилцаатай орнуудтай шинэ нөхцөлд зохицуулан сэргээн хөгжүүлж буй харилцаанд гарсан ахицыг бататгаж, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх чиглэлээр ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Монгол Улсын нэгдэн орсон олон талт гэрээ, конвенцийн орчуулгыг баталгаажуулж, хэвлэн нийтлүүлнэ. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Гадаадад байгаа монгол иргэд, аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг хамгаалах механизмыг боловсронгуй болгох, консулын албыг бэхжүүлэх арга хэмжээ авна. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Монгол Улсын иргэд гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, хилийн чанадад суралцах, хөдөлмөр эрхлэхэд хууль, эрх зүйн аль болох таатай орчин бүрдүүлэхэд урьдын адил анхаарч ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил<br>Ц.Нямдорж |
| | -Дипломат албыг мэргэшсэн төрийн тусгай албаны хувьд эрх зүй, эдийн засаг, нийгмийн хамгааллын чиглэлээр бэхжүүлэх, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний өндөр мэдлэгтэй боловсон хүчнээр хуулийн хүрээнд сэлбэх журмыг тууштай хэрэгжүүлж, Монгол Улсын Дипломат албаны тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах чиглэлээр ажиллана. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Монгол Улсын Дипломат төлөөлөгчдийн газруудын байршлыг илүү оновчтой, үр ашигтай тогтоох, дипломатуудын ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах талаар санал боловсруулж, шат дараалалтай хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Монголын түүх, соёл, өнөөгийн байдлыг гадаад ертөнцөд сурталчлах, Монголын тухай зөрөг ойлголт бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | -Монгол Улсын иргэд, төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллагууд гадаад улс, орнуудтай хүмүүнлэгийн харилцаа тогтоон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | жилдээ | Ц.Мөнх-Оргил |
| | **НАЙМ. ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГО** | | |
| 1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох, иргэдийн амгалан тайван, аюулгүй байдлыг хангах, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд | -Нийгмийн бүх шатанд авилгалтай тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, албан тушаалын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэхэд чиглэсэн үр дүнтэй систем бүрдүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -НҮБ-ын авилгалын эсрэг конвенцид нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлэнэ. | жилдээ | Ц.Нямдорж<br>Ц.Мөнх-Оргил |
| | -Албан тушаалтнуудын орлогын мэдүүлгийг нээлттэй болгоно. | жилдээ | Ц.Нямдорж<br>С.Баярцогт<br>Ж.Норовсамбуу |
| | -Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бүх шатны зөвлөлүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Иргэдэд цагдаагийн ажил, үйлчилгээг ойртуулах зорилгоор гэр хороолold цагдаагийн байнгын пост /"Кобан"/-ын үйл ажиллагааг тогтмолжуулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан торгуулийг бэлэн мөнгөний хэлбэрээр ногдуулж байгаа журмыг өөрчилж төлбөр тооцоог бэлэн бусаар хийх асуудлыг судалж шийдвэрлэнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Цагдаагийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын харилцан үйл ажиллагааг сайжруулна | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хууль хяналтын байгууллагад ажиллагсдын цалин хангамжийг нэмэгдүүлж, тэдэнд тавих хуулийн шаардлагыг чангатгана. | жилдээ | Ц.Нямдорж<br>Ц.Баярсайхан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Улс үндэстэн дамнасан зэрэг шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажлын зохион байгуулалт, бэлэн байдлыг сайжруулж үр дүнг дээшлүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Замын хөдөлгөөнд хяналт тавих телекамерийн хяналтын системийг бий болгож, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж<br>Г.Батхүү |
| | -Мал хулгайлах, архидан согтуурахтай тэмцэх асуудалд эрс өөрчлөлт гаргана. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Бие хүний өгөгдөл, гарын хурууны хээ, нүдний цөцгийн тусгайн мэдээллийн улсын нэгдсэн сан байгуулах асуудлыг судалж санал боловсруулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Цагдаагийн байгууллагын автомашины паркийг шинэчлэх, нийслэлийн цагдаагийн байгууллагад холбоо, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээ нэвтрүүлэх, алба хаагчийн үүргээ биелүүлэх бололцоо, нөхцөлийг сайжруулах, галт зэвсэг, сум, дүрэмт хувцас, тусгай хэрэгслээр хангах болон офицер, ахлагчдын нийгмийн хангамжийг сайжруулах ажлын хүрээнд орон сууцны асуудлыг дэс дараатай шийдвэрлэнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоог боловсронгуй болгон шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Олон улсын гэрээ, эрх зүйн бусад баримт бичгийн судалгаа хийж, олон улсын гэрээний нэгдсэн сан байгуулахын зэрэгцээ Монгол Улсын хууль тогтоомжийг нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх ажлыг нэг бүрчлэн судалж шийдвэрлэнэ. | жилдээ | Ц.Нямдорж<br>Ц.Мөнх-Оргил |
| | -Үндэсний хууль тогтоомжийн системчлэлийг боловсронгуй болгох эрх зүйн мэдээллийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Гэмт хэрэг, гэм буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх зохистой механизмыг судалж, эрх зүйн үндсийг нь бүрдүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Төсөв, гадаадын зээл, тусламж, татвар, нийгмийн даатгалын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад олон нийтийн зүгээс хяналт тавих, энэ чиглэлээр бий болсон өр төлбөрийг барагдуулах зохистой механизм бүрдүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж<br>Н.Алтанхуяг |
| | -Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх талаар нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хуульч боловсон хүчний боловсрол, мэдлэг чадвар, ёс зүйд тавих шаардлагыг өндөржүүлж, тэдгээрийг давтан сургах, сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгоно. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Барааны тэмдгийн тухай хуулийн гэрээ, Патентийн тухай хуулийн гэрээнд Монгол Улс нэгдэн орох боломжийг судална. | жилдээ | Ч.Улаан |
| | -Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг судлан санал боловсруулж шийдвэрлэнэ. | I-II улирал | Ц.Нямдорж |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Төлбөрийн чадваргүй, бага орлоготой иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог бий болгох асуудлыг судална. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Үндэсний төв архивыг орчин үеийн, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үргэлжлүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | - Гадаадын шүүх, арбитрын шийдвэр, даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хоёр талын иргэдийн эрх ашгийг харилцан хамгаалах чиглэлээр АНУ, ХБНГУ, Канад Улстай эрх зүйн туслалцааны болон гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллана. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхэлсэн албыг олон улсын жишигт нийцүүлж, статусыг нь шинэчлэн тогтооно. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Иргэний бүртгэл, мэдээллийн албаны үйл ажиллагааг боловсронгуй болгоно. | жилдээ | Ц.Нямдорж |
| 2.Улсын хил хамгаалалтын чадавхийг бэхжүүлж хүн хүч, тэхник, технологи, санхүүгийн хүчин чадлыг сайжруулан, аюулгүй байдлыг хамгаалах тусгай байгууллагуудын санхүүгийн чадавхийг сайжруулах зорилтын хүрээнд | -Хил хамгаалалтын ажилд онцгой анхаарал хандуулж, "Дархан хил" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хилийн отряд, застав, харуулуудыг тоон радио релейний системээр холбоожуулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хилийн заставуудыг суудлын авто машин, цасны чарга, хүнд даацын авто машинаар хангах асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хилийн зөрчил, малын хулгай ихтэй хилийн хэсэгт хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хил хамгаалалтад сансрын холбоо, тоон мэдээллийн технологийг өргөн ашиглана. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хил хамгаалагчдын шилжилт хөдөлгөөн хийх чадварыг эрс нэмэгдүүлж, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг сайжруулна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хүний нөөцийн хөгжилд онцгой анхаарч, хилчдийн ахуй амьдралыг дээшлүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Улсын хил хамгаалалтад нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хилийн хязгаар нутагт амьдарч буй иргэдэд төрийн нийтлэг үйлчилгээг хүргэхэд түлхүү анхаарна. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Тагнуулын албыг өндөр мэргэшилтэй албан хаагчдаар бүрдүүлэхэд анхаарч, гүйцэтгэх ажлын шинэ техник хэрэгсэл, аргыг нэвтрүүлнэ. | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Терроризмаас урьдчилж сэргийлэх, түүнийг гаргахгүй байх бэгц арга хэмжээ авна. | жилдээ | Ц.Нямдорж<br>С.Баярцогт |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 27 | Улаанбаатар хот

### Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн /, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг Улсын Их Хуралд улирал тутам танилцуулж байхыг Монголбанк /О.Чулуунбат/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

*Монгол Улсын Их Хурлын 2004 оны 27 дугаар тогтоолын хавсралт*

### ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2005 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэл нь санхүүгийн зуучлалын хэмжээ болон өрсөлдөөн нэмэгдэж байгаа орчинд төгрөгийн болон банкны тогтолцооны тогтвортой байдлыг хадгалахад чиглэгдэнэ.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанк дараахь үйл ажиллагааг явуулна:

- Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг жилийн 5 хувиас хэтрүүлэхгүй байхыг зорино.
- Дунд болон урт хугацааны санхүүгийн хэлцлүүд буюу орон сууц, газар болон бусад үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан зээл олголтын тогтолцоог сайжруулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Төгрөгийн форвард зах бий болгох дэд бүтэц, бизнес эрхлэгчдийн санаачлагыг дэмжинэ.
- Гадаад, дотоод зах зээлээс хөрөнгө оруулалт, хямдралтай санхүүжилтийн эх үүсвэр дайчлан эдийн засгийн эргэлтэнд оруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.
- Мөнгөний бодлогын холбогдолтой судалгааг эрчимжүүлэн Монгол Улсын эдийн засгийг загварчлах ажлыг Засгийн газартай хамтран эхлүүлнэ.
- Үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор гадаадаас хямд эх үүсвэртэй фонд /зээл/ дайчилж, арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
- Банк, санхүүгийн хөгжлийн тогтвортой байдлыг хадгалах, эдийн засаг дахь зээл, санхүүгийн орчныг таатай болгох зорилгоор банкны барьцаа хөрөнгийг захиран зарцуулахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэргээр санхүүгийн харилцаанд оролцогчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх чиглэл баримтална.
- Банк, санхүүгийн зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжих, банкны үйл ажиллагааны эрсдлийг бууруулах, активын багцын чанарыг дээшлүүлэх зорилгоор олон улсын туршлага дээр үндэслэн банк, санхүүгийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг дэмжинэ.
- Банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах, банк бус санхүүгийн зах зээлийн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлчлүүлэгчдийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах үүрэгтэй Санхүүгийн зохицуулах хороог байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх арга хэмжээ авна.
- Хяналт шалгалтын үйл ажиллагааг эдийн засгийн ерөнхий төлөв байдалтай уялдуулах чиглэлийг баримтална.
- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүдийн үйл ажиллагааг жигдрүүлж, хөгжлийг нь улам боловсронгуй болгох талаар нэгдсэн зохицуулалт хийнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар 182 | Улаанбаатар хот

### Гарамжавын Сундуйжавт улсын тод манлай уяач цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 3, 6 дугаар заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Монгол түмний цэнгэлийн манлай-Үндэсний их баяр наадмын болон шигшмэл, бүсийн хурдан морины уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлгыг тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулж, наадамч олноо баясгасан Нийслэлийн Налайх дүүргийн харъяат, уяач Гарамжавын Сундуйжавт улсын тод манлай уяач цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар 183 | Улаанбаатар хот

### Зарим уяачид улсын манлай уяач цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 3, 6 дугаар заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Үндэсний их баяр наадмын болон шигшмэл, бүсийн хурдан морины уралдаанууддад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлгыг тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулж, уяачийн эрдэм чадвар, эв хавыг гайхуулсан дор дурдсан хүмүүст улсын манлай уяач цол олгосугай.

1.Гончигжавын Алтангэрэл-Дорноговь аймгийн Сайншанд сумын харьяат, уяач

2.Цэрэнгийн Хэнмэдэх-Төв аймгийн Сэргэлэн сумын харьяат, уяач

3.Лувсанцэрэнгийн Чойдог-Төв аймгийн Баян-Өнжүүл сумын харьяат, уяач

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 06-ны өдөр | Дугаар 184 | Улаанбаатар хот

### Зарим уяачид улсын алдарт уяач цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 3, 6 дугаар заалтыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Үндэсний их баяр наадмын болон шигшмэл, бүсийн хурдан морины уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлгыг тааруулан түрүү магнай, айргийн тавд хурдлуулан, өндөр амжилт гаргасан дор дурдсан хүмүүст улсын алдарт уяач цол олгосугай.

1.Галын Баттөмөр-Төв аймгийн Баянжаргалан сумын харьяат, уяач

2.Цэндийн Бямбадорж -Сүхбаатар аймгийн Дарьганга сумын харьяат, уяач

3.Гарамжавын Ганбат-Нийслэлийн Налайх дүүргийн харьяат, уяач

4.Доржийн Сүхээ-Увс аймгийн Өндөрхангай сумын харьяат, уяач

5.Ганхүрэлийн Сэргэлэнбаатар –Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын харьяат, уяач

6.Доржсүрэнгийн Цэнд-Аюуш-Увс аймгийн Өндөрхангай сумын харьяат, уяач

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 08-ны өдөр | Дугаар 186 | Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Филиппин Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Агваандоржийн Цолмонг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Филиппин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Баасанжавын Ганболдыг тохоон томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 12 дугаар сарын 08-ны өдөр | Дугаар 187 | Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Агваандоржийн Цолмонг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Баасанжавын Ганболдыг тохоон томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2004 оны 10 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 95 | Улаанбаатар хот

**Мэдээлэл,харилцаа холбоо,технологийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр батлах тухай**

1. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсан нэгжтэй байхаар батлавсугай:

а/Бодлого төлөвлөлтийн хэлтэс;

б/Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын хэлтэс;

в/Төрийн захиргаа, хамтын ажиллагааны хэлтэс.

3. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын орон тоог 27 (хорин долоо)-гоос, зардлыг 123.2 (нэг зуун хорин гурван сая хоёр зуун мянган) сая төгрөгөөс дээшгүй байхаар тогтоосугай.

4. Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төвийг үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих зарчмаар ажиллуулж, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг баталж мөрдүүлэхийг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын даргад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

Ерөнхий сайдын 2004 оны 95 дугаар захирамжийн хавсралт

## МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР

1.0.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-т Засгийн газар болон Ерөнхий сайдаас мэдээлэл, харилцаа холбоо, технологийн асуудлаар стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, эрх зүйн орчинг бүрдүүлэх, бодлогын удирдамж, удирдлага, зохицуулалтаар хангах, хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ хийх, үнэлэх зэрэг асуудлыг хамруулан боловсруулав.

1.2. Агентлаг байгуулах үндэслэл

Дэлхийн улс орнууд эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн хөгжлийг хурдасгагч үндсэн хэрэгсэл болох мэдээллийн технологийг ашиглан мэдлэг оюунд тулгуурласан мэдээлэлжсэн нийгэм байгуулах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Өнгөрсөн жилүүдэд мэдээллийн технологийн ололтыг салбар тус бүр зөвхөн өөрийн хэрэгцээг хангахуйц өөр хоорондоо болон иргэдтэй харилцан мэдээлэл солилцох боломж дутмаг мэдээллийн системийг бүрдүүлж иржээ. Нэгэнт бий болсон мэдээллийн эдгээр системийг нэгтгэн зохион байгуулах, цаашдын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, харилцан уялдаж мэдээлэл солилцох чадамжийг дээшлүүлэх, төрийн мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт амжилттай нэвтрүүлснээр шинэ эдийн засгийг бий болгон мэдээлэлжсэн нийгмийн үндэс суурь бүрдэх юм. Иймд мэдээлэл, харилцаа холбооны технологийг Улсын Их Хурал, Засгийн газраас төрийн бодлогын тэргүүлэх чиглэл гэж үзэн энэхүү салбарын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог шинээр бий болгож Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар байгуулахаар шийдвэрлэсэн болно.

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар нь мэдээлэл, харилцаа холбооны технологийг бусад салбарын хөгжлийг дэмжих хэрэгсэл болгон хөгжүүлэх, тэдгээрийн ажлын уялдааг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, өнөөгийн бүтэц, зохион байгуулалтыг салбар дамнасан бүтцэд шилжүүлэн үйл ажиллагааны үр нөлөө, өгөөжийг дээшлүүлэх стратегийн бодлого, зохицуулалт, шуурхай удирдамжаар хангах, зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага болж, ирээдүйн мэдээлэлжсэн нийгэмд хүрэх стратегийн хэтийн зорилтуудыг тодорхойлон түүнийг хэрэгжүүлэх, зохицуулах үйл ажиллагааг байнгын удирдлагаар хангах зорилготой юм. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжих бөгөөд төрийн захиргааны бусад байгууллагын чиг үүрэг, үйлчилгээтэй давхардаагүй болно.

1.3. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

Энэ хөтөлбөрийг Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоол, Монгол улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртлэх үзэл баримтлалыг батлах тухай Улсын Их Хурлын 2000 оны 21 дүгээр тогтоол, Мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги батлах тухай Засгийн газрын 2002 оны 232 дугаар тогтоол, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг тус тус үндэслэн боловсруулав.

1.4. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

·Монгол Улсын Үндсэн хууль;

·Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;

·Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;

·Төрийн албаны тухай хууль;

·Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;

·Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль;

·Харилцаа холбооны тухай хууль;

·Шуудангийн тухай хууль;

·Радио долгионы тухай хууль;

·Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль;

·Бусад хууль тогтоомж.

1.5. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, өөрчлөлтийн удирдлага; үйл ажиллагааны төлөвлөлт болон дахин инженерчлэл; байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг тус тус хэрэглэв.

1.6. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар нь Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлээрх мэдээлэл, харилцаа холбооны технологийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж, Ерөнхий сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар нь салбарын бодлого, төлөвлөлтийн үндсэн чиг үүргийг хүлээж, бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар нь мэдээллийн технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх, цахилгаан холбоо, радио, телевизийн дэд бүтцийг сайжруулах, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой асуудлуудыг хамарсан зөвлөх, хэрэгжүүлэгчийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1.7. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой тодорхойлох нь Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

**МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР**




Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Ерөнхий сайд, Засгийн газрын Танхим байна. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэнэ.

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.0. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратеги

2.1. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын зохицуулалт, дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Төрөөс мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар баримтлах бодлого, хуулиуд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжилтийг зохион байгуулахад Ерөнхий сайдад бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үндсэн үйл ажиллагааг салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулахад чиглүүлснээр төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

3. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, ажлын байрны давхардлыг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэн чадваржуулах замаар чадварлаг, цомхон алба болгох;

4. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын зүгээс үзүүлэх төрийн үйлчилгээг соёлтой, чанартай, ил тод, нээлттэй, шуурхай болгох.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

**Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын эрхэм зорилго нь** мэдээлэл, холбооны технологийг 21 дүгээр зууны Монгол Улсын хөгжлийн үндсэн хурдасгуур гэж үзэж мэдлэг оюунд тулгуурласан мэдээлэлжсэн нийгмийг хөгжүүлэхэд оршино.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн стратеги төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.4.2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

2.4.3. Удирдлагын манлайллыг хангах.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн бодлогын үндэслэл, урт, дунд, богино хугацааны төлөвлөлт, шинэтгэлийн бодлогын удирдамжаар хангахад зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх;

2.5.1.2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх;

2.5.1.3. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөлгөө өгөх, дэмжлэг үзүүлэх.

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн шинэтгэлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.2.2. Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах;

2.5.2.3. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын материаллаг нөөц, хангамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн төрийн захиргааны удирдлагын манлайлал, хөрөнгө санхүүгийн удирдлага, дотоод үйлчилгээгээр хангах;

2.5.3.2. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын хүний нөөц, хамтын ажиллагааны зохицуулалтад дэмжлэг үзүүлэх;

2.5.3.3. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх, салбарын бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны дээр дурдсан гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус газар тодорхойлж хэрэгжүүлнэ. Ойрын хугацаанд дараах зорилтуудыг эхний ээлжинд хэрэгжүүлнэ:

2.6.1. Үйл ажиллагааны 2.5.1.2 гол зорилтын хүрээнд:

2.6.1.1. Мэдээллийн технологийн багц хуулийн төслийг боловсруулж батлуулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлэх;

2.6.2. Үйл ажиллагааны 2.5.1.3 гол зорилтын хүрээнд:

2.6.2.1. "Цахим Монгол" хөтөлбөр боловсруулж батлуулах;

2.6.2.2. "Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хүний нөөцийн чадавхи" хөтөлбөр, төслийг боловсруулах;

2.6.2.3. "Төрийн мэдээллийн нэгдсэн систем" хөтөлбөр боловсруулах;

2.6.2.4. Электрон арилжааг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах;

2.6.2.5. "Кодчлол" хөтөлбөр боловсруулах;

2.6.2.6. "Бүх нийтийн компьютержуулалт" хөтөлбөр боловсруулж батлуулах.

2.6.3. Үйл ажиллагааны 2.5.2.1 гол зорилтын хүрээнд:

2.6.3.1. "Цахим Монгол" хөтөлбөрийг улс орны хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхлэх;

2.6.3.2. "Төрийн мэдээллийн нэгдсэн систем" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.6.3.3. "Кодчлол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэх;

2.6.3.4. "Бүх нийтийн компьютержуулалт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах.

2.6.4. Үйл ажиллагааны 2.5.3.2 гол зорилтын хүрээнд:

2.6.4.1. "Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хүний нөөцийн чадавхи" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

**Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загвар**



3.0. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчим баримтлав:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн агентлагийн стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус агентлагийн үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

2. Эрх мэдлийн зааг ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал агентлагийн ажлын алба, түүний бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн агентлагийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн /гурваас дээшгүй/ шат дамжлагатай байх);

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн агентлагийн төрийн захиргааны албан хаагч нь Ерөнхий Сайд, Засгийн газар (Танхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх);

7. Хангалттай чадвар, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус газрын үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

**Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагаа (бизнес)-ны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар**



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас тус газрын зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгж урган гарч байна:

1. Нэгдсэн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд салбарын хууль эрх зүйн шинэчлэлт хийх, хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн бодлогын үндэслэл, урт, дунд, богино хугацааны төлөвлөлт, хөтөлбөр, төсөл боловсруулах, салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх, зөвлөмжөөр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үндсэн чиг үүрэг нь эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, программ хангамжийн үйлдвэрлэл, мэдээлэлжүүлэлт, компьютержуулалт, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлт, салбарын эдийн засгийн үр ашиг нэмэгдүүлэх, үнэ тарифын бодлого, цахилгаан холбоо, радио телевиз, тусгай зориулалтын зэрэг сүлжээг хөгжүүлэх техник технологийн төлөвлөлт, радио долгионы төлөвлөлт, сансрын болон хөдөлгөөнт холбоог хөгжүүлэх, мэдээлэл холбооны бүх нийтийн үйлчилгээ ба хүртээмж, салбарын стандартчилал, холбооны сүлжээний дугаарлалт, интернэтийн домайн нэр, мэдээлэл холбооны шинэ төрлийн үйлчилгээ хэрэглэгчээг нийгэм, эдийн засгийн бусад салбарт нэвтрүүлэх бодлого, стратеги, төлөвлөлтийг боловсруулахад оршино.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь Ерөнхий сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, газрын удирдлагад шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, бусад байгууллага байна.

2. Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын хөгжлийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнийг зохицуулах, салбарын материаллаг нөөцийн хуваарилалт, ашиглалтын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарыг хөгжүүлэх нэгдсэн бодлогын хэрэгжилтийг зохицуулахад чиглэнэ.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой зохицуулах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар

эрэгжинэ. Энэ нь Мэдээлэл, харилцаа холбоо, эхнологийн газрын эрхлэх асуудлын хүрээнд жиллаж байгаа төсөвт байгууллага, аж ахуйн эгжийн үйл ажиллагаанд шаардлагатай удирдамж эвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх змаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн эрэглэгч нь Мэдээлэл, харилцаа холбоо, ехнологийн газрын дарга байх бөгөөд бусад эрэглэгч нь яамд, Засгийн газрын холбогдох охируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, шууд бус хэлбэрээр энэ йлчилгээг хэрэглэгч нь төрийн ба төрийн бус айгууллага, аж ахуйн нэгж, иргэд байна.

3. Захиргаа, хамтын ажиллагааны асуудал рхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний ндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, хамтын ажиллагаа, салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад чиглэнэ. Энэ нь Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ. Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дүнг ажиглах, үнэлж дүгнэх замаар Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа харъяа болон салбарын бусад байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангаж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Мэдээлэл, харилцаа холбоо технологийн газрын дарга, газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь салбарын байгууллага, тэдгээрийн удирдлага байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**"Төрийн Мэдээлэл"** эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 5